**Загвар төлөвлөгөө**

БАТЛАВ
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГА С.МӨНХЧУЛУУН

2026 оны ... дугаар сарын ...-ны өдөр

# ДУНДГОВЬ АЙМГИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

ТАНИЛЦСАН:
ОБЕГ-ЫН АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА,

ХЯНАСАН:
ОБЕГ-ЫН АУГ-ЫН ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨЛТ, БЭЛЭН БАЙДЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА,

БОЛОВСРУУЛСАН:
АЖЛЫН ХЭСГИЙН ДАРГА ........................

МАНДАЛГОВЬ ХОТ
2026 ОН

# ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТОДОТГОЛ ХИЙСЭН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ

| № | Төлөвлөгөөг тодотгосон албан тушаалтан, овог нэр | Тодотгол хийсэн он, сар, өдөр | Хуудасны дугаар | Мөрийн дугаар | Тодотгол хийсэн товч утга |
|---|---|---|---|---|---|
| 1. | | | | | |
| 2. | | | | | |
| 3. | | | | | |
| 4. | | | | | |
| 5. | | | | | |
| 6. | | | | | |
| 7. | | | | | |
| 8. | | | | | |
| 9. | | | | | |
| 10. | | | | | |
| 11. | | | | | |
| 12. | | | | | |
| 13. | | | | | |
| 14. | | | | | |
| 15. | | | | | |
| 16. | | | | | |
| 17. | | | | | |
| 18. | | | | | |

**АГУУЛГА**


НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Үндэслэл

1.2. Зорилго

1.3. Хамрах хүрээ

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ АРГА ХЭМЖЭЭ

2.1. Дундговь аймгийн гамшгийн эрсдэлийн үнэлгээ

2.2. Гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээ

2.3. Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах

2.4. Гамшгаас хамгаалах сургалт

2.5. Гамшгаас хамгаалах албадын чиг үүрэг

ГУРАВДУГААР БҮЛЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

3.1. Гамшгийн үеийн зохион байгуулалтын арга хэмжээ

3.2. Гамшгаас хамгаалах удирдлага, зохион байгуулалтын бүтэц

3.3 Гамшгийн үеийн удирдлага, зохицуулалт

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ ДАМЖУУЛАХ

4.1. Гамшиг, аюулт үзэгдэл, ослын мэдээллийг байгууллагуудад дамжуулах

4.2. Гамшиг, аюулт үзэгдэл, ослын мэдээллийг иргэдэд дамжуулах

ТАВДУГААР БҮЛЭГ. ГАМШГИЙН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ

5.1. Гамшгийн үеийн удирдлага, зохицуулалт

5.2. Газар хөдлөлтийн гамшгийн хариу арга хэмжээ

5.3. Үерийн гамшгийн хариу арга хэмжээ

5.4. Ой, хээрийн гал түймрийн хариу арга хэмжээ

5.5. Хүчтэй салхи, шуурганы гамшгийн хариу арга хэмжээ

5.6. Зудын гамшгийн хариу арга хэмжээ

5.7 Уул уурхайн ослын хариу арга хэмжээ

5.8. Химийн ослын хариу арга хэмжээ

5.9. Мал, амьтны гоц халдварт өвчний хариу арга хэмжээ

ЗУРГААДУГААР БҮЛЭГ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

6.1. Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний удирдлага зохицуулалт

6.2. Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

ДОЛООДУГААР БҮЛЭГ. ХҮЧ ХЭРЭГСЭЛ ДАЙЧЛАН ГАРГАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

7.1. Хүч хэрэгсэл дайчлан гаргах үйл ажиллагааны удирдлага зохицуулалт

7.2. Гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах төлөвлөгөө

НАЙМДУГААР БҮЛЭГ. ХАНГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

8.1. Хангалт зохион байгуулах байгууллага

8.2. Хангалт зохион байгуулах арга хэмжээ

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ. ХҮМҮҮНЛЭГИЙН ТУСЛАМЖ, ДЭМЖЛЭГ

9.1. Хүмүүнлэгийн тусламжийн удирдлага зохицуулалт

9.2. Дотоодын хүмүүнлэгийн тусламжийг зохион байгуулах арга хэмжээ

АРАВДУГААР БҮЛЭГ. ТӨСӨВ, САНХҮҮ

АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БУСАД

# ДУНДГОВЬ АЙМГИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

### 1.1. Үндэслэл

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах алба, хуулийн этгээд гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй байна”, 32 дугаар зүйлийн 32.1.1 Засаг даргын бүрэн эрхт “Нутаг дэвсгэрийн хэмжээнд гамшгаас хамгаалах арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, удирдах, хэрэгжүүлэх”, Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг үндэслэн Дундговь аймгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулав.

### 1.2. Зорилго

Нутаг дэвсгэрийн хэмжээнд урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, гамшгийн үеийн бэлэн байдлыг хангах, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх арга хэмжээг удирдлага зохион байгуулалтаар хангахад оршино.

### 1.3. Хамрах хүрээ

1.3.1.Энэхүү төлөвлөгөөг Дундговь аймгийн хэмжээнд эсхүл хэд хэдэн сумдын хэмжээнд тохиолдсон гамшгийн нөхцөл байдал үүссэн үед хэрэгжүүлнэ.

1.3.2. Аймгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө нь Онцгой комисс,  сумдын Онцгой комисс, шуурхай штабууд, орон нутгийн гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагууд, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх харилцааг зохицуулна.

1.3.3. Гамшгийн үед тухайн шатны Онцгой комисс, төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагаас тогтоосон газарт, заасан хугацаанд томилгоот хүч хэрэгслийг бэлэн байлгах, техник, багаж  хэрэгсэл, хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хөдөлмөр хамгааллын хувцсаар хангах үүргийг яам, агентлаг, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллага хүлээнэ.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ. ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ АРГА ХЭМЖЭЭ

### 2.1. Дундговь аймгийн гамшгийн эрсдэлийн үнэлгээний үр дүн

2020-2023 оны хугацаанд үндэсний болон орон нутгийн хэмжээнд гамшгийн эрсдэлийн үнэлгээг зонхилон тохиолддог гамшгийн төрөл тус бүрээр засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, хүн ам, айл өрх,  барилга байгууламж, орон сууц, гэр, дэд бүтэц, мал, газар тариалан-ургац зэрэг олон элементүүдийг хамруулан 2020 оны мэдээлэлд суурилан гүйцэтгэж, анх удаа гамшгийн аюул, өртөх байдал, эмзэг байдлын зураглалыг дан болон олон аюулын төрлөөр боловсруулсан.

Дундговь аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж (15 сум, 68 баг)-ийн түвшинд гамшигт өртөх байдлыг гамшгийн төрөл тус бүрээр авч үзвэл **маш их** газар хөдлөлт 100%, шороон шуурга 100%, ган 98.5 %, зуд 97.1%, **их** цасан шуурга 63.2%,  **дунд** хүчтэй салхи шуурга 51.5%, **бага** хээрийн гал түймэр 21.1%, **маш бага** үер 5.9% байна.

Олон аюулын үнэлгээний аюулын эрчим нь 68 багийн 69.1 хувь буюу 47 багийн нутаг дэвсгэр **дунд** түвшин, 30.9 хувь буюу 21 баг **их** гэсэн түвшинд хамрагдаж байна.

Төв суурин газрын 4 баг олон аюулд өртөх байдлын дунд түвшин, 5 баг их түвшинд, хөдөөний 59 багийн 43 баг нь олон аюулын **дунд** түвшинд, 16 баг нь **их** түвшинд байна.

Төв суурин газрын хүн ам 75%, хөдөөгийн хүн амын 68% нь олон аюулд өртөх байдлын дунд оршиж байгаа бөгөөд гамшгийн эрсдэл дунд түвшин байна.

| Аюул | Мэдээлэл | Өртөх байдалд байгаа багуудын тоо | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Маш бага | Бага | Дунд | Их | Маш их |
| Олон аюул | Нийт баг | 0 | 0 | 47 | 21 | 0 |
| | Төв суурин газрын баг | 0 | 0 | 4 | 5 | 0 |
| | Хөдөөгийн баг | 0 | 0 | 43 | 16 | 0 |

Хүснэгт 1. Дундговь аймгийн гамшгийн олон аюулд өртөх байдал (сум, баг)

**2.2. Гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.**

| д/д | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хугацаа | Хариуцах байгууллага | Хамтран хэрэгжүүлэх байгууллага |
|---|---|---|---|---|
| 1. | Гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээнд шаардлагатай зардлыг тухайн жилийн төсөвт тусгах | IV улирал | ИТХ | ГЭБОНЗ, ОБГ |
| | Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, хагас жил тутам тайлагнах | I-IV улирал | ГЭБОНЗ | ГЭБОНЗ-ийн гишүүд |
| | Гамшгийн эрсдэлийг бууруулахтай холбоотой зөвлөмж боловсруулах, байгууллагуудад хүргүүлж шийдвэрлүүлэх | Тухай бүр | | ГЭБОНЗ-ийн гишүүд |
| | Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагаа, иргэдийн оролцоог хангах | I-IV улирал | | ГЭБОНЗ-ийн гишүүд |
| | Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлөөс гаргасан зөвлөмжийн хэрэгжилтийг хангах | I-IV улирал | | ГЭБОНЗ-ийн гишүүд |
| | Гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр бүтцийн болон бүтцийн бус арга хэмжээг хэрэгжүүлэх | I-IV улирал | | Аймгийн ЗДТГ |
| | Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд шинжлэх ухаан, техник технологийн шинэ ололт, инновацийг нэвтрүүлэх | I-IV улирал | | ГЭБОНЗ-ийн гишүүн байгууллагууд |
| | Гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээллэх, сурталчлах | I-IV улирал | | ОБГ |
| 2. | Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах, | I, IV улирал | Газрын харилцаа, Барилга хот | ОБГ |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | байгуулалтын газар Аймгийн ГХБАСЗ | |
| | Барилга байгууламжид тэсвэржилтийн үнэлгээг хийлгэх, шаардагдах зардлыг шийдвэрлүүлэх, | I-IV улирал | Аймгийн ГХБАСЗ | Аймгийн ЗДТГ |
| | Сургууль цэцэрлэг, эмнэлгийн барилга байгууламжийг хүчитгэх арга хэмжээг зохион байгуулах, шаардагдах зардлыг шийдвэрлүүлэх, | I-IV улирал | | Аймгийн ЗДТГ |
| 3. | Аймгийн хөгжлийн бодлого, Засаг даргын мөрийн хөтөлбөрт гамшгаас хамгаалах арга хэмжээг тусгах; | 2024-2028 он | ЗДТГ | ЗДТГ-ын харьяа нэгжүүд |
| | Засаг захиргаа нутаг дэвсгэрийн хэмжээнд гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх; | 3 жил тутам | | АОК |
| | Нэгдсэн Үндэсний Байгууллагын Гамшгийн эрсдэлийг бууруулах газраас хэрэгжүүлж буй “Аюулгүй, гамшигт тэсвэртэй хот” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах; | 3 жил тутам | | Захирамжаар томилогдсон ажлын хэсэг |
| | Бага дунд төвөгшилтэй барилга байгууламж, ашиглалтын шаардлага хангахгүй барилгыг хүчитгэх, буулгаж шинээр барих ажлыг төлөвлөх, зардлыг холбогдох үе шаттай шийдвэрлэх, төсөвт тусгах, хэрэгжүүлэх | Тухай бүр | Газрын харилцаа, Барилга хот байгуулалтын газар | ЗДТГ, хуулийн этгээд |
| | Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн эх үүсвэр, гамшгаас хамгаалах болон орон нутгийн нөөцийг бүрдүүлэх, зарцуулах | Жилдээ | ЗДТГ | ИТХ, ГХОНА |
| | Харилцаа холбоо, зарлан мэдээлэх системийн байнгын бэлэн байдлыг хангуулах, нөөц эх үүсвэрийг бүрдүүлэх; | I-IV улирал | Мэдээлэл, харилцаа холбооны алба | Аймаг, сумдын ЗДТГ, ОБГ, ГХОНА |
| | Иргэдийг нүүлгэн шилжүүлэх, түр цугларах талбай, түр байрыг томилгоожуулах, бэлтгэх, газрын баталгаажуулах | I-IV улирал | Газрын харилцаа, Барилга хот байгуулалтын газар | Аймаг, сумдын ЗДТГ, ОБГ |
| | Орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэг мэдээлэл, сурталчилгааг иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулах | I-IV улирал | Орон нутаг дахь хэвлэл мэдээллийн тусгай зориулалтын мэргэжлийн анги | Аймаг, сумдын ЗДТГ, ОБГ |
| | Цацраг, хими, биологи, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг үйлдвэрийн болон хадгалах байр, агуулахад тогтоосон аюултай бүсийн хил хязгаарт иргэд болон аж ахуйн нэгж, байгууллагад газар олгохгүй байх; | I-IV улирал | Газрын харилцаа, Барилга хот байгуулалтын газар | Аймаг, сумдын ЗДТГ |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | Байгаль, цаг агаарын гамшигт болон аюулт үзэгдлийн нөлөөллийн үнэлгээг тухай бүр хийх, урьдчилсан мэдээ, мэдээллиййг олон нийтэд хүргэх; | Тухай бүр | УЦУОШТ | Аймаг, сумдын ЗДТГ, ОБГ |
| | Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нөөцийн судалгаа гаргах, нөөцийг нөхөн бүрдүүлэлтийг зохион байгуулах; | I-IV улирал | Хүнс хөдөө аж ахуйн газар | ЗДТГ, ААНБ |
| | Далан, суваг шуудуу, инженерийн байгууламжийн бэлтгэл арга хэмжээг нарийвчлан төлөвлөх, хэрэгжүүлэх, арчлах хуваарийг гаргах; | I-IV улирал | Газрын харилцаа, Барилга хот байгуулалтын газар | Аймаг, сумдын ЗДТГ |
| | Түлш, эрчим хүчний тасралтгүй найдвартай ажиллагааг хангуулах, нөөц эх үүсвэрийг бэлэн байлгах; | I-IV улирал | Дундговь Цахилгаан түгээх ОНӨААТҮГ, Түлш эрчим хүчээр хангах алба | ЗДТГ |

**2.3. Гамшгаас хамгаалах албадын чиг үүрэг**

| д/д | Авч хэрэгжүүлэх арга хэмжээ | Албад |
|---|---|---|
| 1. | Хүний гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг зохион байгуулах, холбогдох байгууллагуудтай харилцан ажиллах<br>-Гамшгийн үед нэрвэгдэгсдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх<br>- Шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, цус, цусан бүтээгдэхүүний нөөцийг бүрдүүлэх, бэлэн байдлыг хангах<br>-Дархлаажуулалт, ариутгал, халдваргүйтгэл хийх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах<br>-Төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэр болон түгээх цэгийн үйл ажиллагааны эрүүл ахуйн нөхцөл, аюулгүй байдал, ус хангамжийн тасралтгүй байдлыг хангах<br>- Хээрийн эмнэлэг дэлгэх тооцоо, судалгааг гаргаж, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах,<br>- Аймгийн Онцгой комиссыг мэдээ, мэдээллээр хангах<br>- Орон нутгийн онцлогт тохируулан нэмэлт өөрчлөлт хийж болно. | Эрүүл мэндийн алба |
| | -Цацраг, хими, биологи, тэсэрч дэлбэрэх бодисын хууль бус хэрэглээтэй холбоотой асуудлыг мөрдөн шалгаж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах<br>-Гамшгийн үед эргүүл, хяналтыг гарган аливаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, таслан зогсоох, арга хэмжээг төлөвлөх, бэлэн байдлыг хангуулах<br>-Голомтын бүсэд эргүүл, постуудыг гарган аливаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах<br>-Эрэн хайх, аврах хүч хэрэгслийг голомтод саадгүй нэвтрүүлэх, хязгаарлалтын дэглэм тогтоох, бэлэн байдлыг хангуулах<br>-Улсын онц чухал объектуудын харуул хамгаалалтыг зохион байгуулах<br>-Гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг олон нийтэд хүргэх ажилд дэмжлэг үзүүлж хамтарч ажиллах<br>- Гамшигт нэрвэгдэгсдийн талаарх мэдээлэл цуглуулах, сураггүй алга бологсдыг шалган тогтоох, эрэн сурвалжлах, нас барагчдыг таниулах, нэр хаягийг тогтоох ажлыг зохион байгуулах | Хэв журам сахиулах алба |

| | | |
|---|---|---|
| | - Аймгийн Онцгой комиссыг мэдээ, мэдээллээр хангах<br>- Орон нутгийн онцлогт тохируулан нэмэлт өөрчлөлт хийж болно. | |
| 2. | -Байгаль, цаг агаарын гамшигт болон аюулт үзэгдлийн тухай урьдчилсан мэдээ, мэдээлэл, сансрын хиймэл дагуулын үзэгдлийн зураглал гаргах, олон нийт, иргэдэд мэдээлэх<br>-Байгаль, цаг агаарын гаралтай гамшигт болон аюулт үзэгдэл, цацраг, химийн нөлөөллийн үнэлгээг тухай бүр хийж урьдчилан сэргийлэх мэдээллээр хангах<br>-Цацрагийн ослын тухай мэдээг орон нутаг болон холбогдох мэргэжлийн байгууллагаас хүлээн авч, мэдээлэх, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэх<br>-Гамшгийн үед химийн хорт болон аюултай бодис алдагдах, аюул учрахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах<br>-Цацраг, химийн хорт болон аюултай бодисоос үүдэлтэй ослын хор уршгийг арилгах хариу арга хэмжээг удирдлага зохион байгуулахад шаардлагатай багаж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, материал хэрэгслийн нөөц бүрдүүлэх, нэмэгдүүлэх бэлэн байдлыг хангуулах арга хэмжээг зохион байгуулах<br>-Цацраг, химийн чиглэлээр аж ахуйн нэгж, байгууллагад ажилдаг мэргэжлийн ажилтануудын бүртгэл, судалгааг хийх<br>-Аймгийн Онцгой комиссыг мэдээ, мэдээллээр хангах<br>- Орон нутгийн онцлогт тохируулан нэмэлт өөрчлөлт хийж болно. | Цаг, уурын болон цацраг, химийн аюулыг үнэлж мэдээлэх алба |
| 3. | -Гамшгийн үед салбарын хэмжээнд тогтвортой байдлыг хангах<br>-Зорилтот бүлгийн иргэдийн судалгааг нарийвчлан гаргаж, гамшгийн үед шаардлагатай урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах<br>-Гамшгийн үед хүүхдийн аюулгүй байдлыг хангах, жендерээс үүдэлтэй хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах<br>-Эмзэг бүлгийн болон эцэг эхийн хараа хяналтгүй хүүхдүүдийн судалгаа гаргах, шаардлагатай бүх талын тусламж үзүүлэх чиглэлээр урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах<br>-Хүүхэд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх, тэдний онцлогт тохирсон гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх мэдлэг, ойлголт олгох<br>-Гамшгийн үед олон нийтэд нийгэм, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах,<br>-Нүүлгэн шилжүүлэх байранд ирсэн иргэдэд нийгмийн хамгааллын тусламж, үйлчилгээ үзүүлэх,<br>- Томилгоосон түр хоргодох байранд иргэдийг байрлуулах ажлыг зохион байгуулах<br>- Аймгийн Онцгой комиссыг мэдээ, мэдээллээр хангах<br>- Орон нутгийн онцлогт тохируулан нэмэлт өөрчлөлт хийж болно. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын алба |
| 4. | -Гамшгийн үед ашиглагдах шаардлагатай тээврийн хэрэгслийн судалгаанд тодотгол хийх,<br>-Улс, хот хоорондын авто замын чиглэлийг өөрчлөх, хаах, нөөц зам гаргах арга хэмжээг зохион байгуулах,<br>-Гамшгийн үед иргэдийг нүүлгэн шилжүүлэх, тээвэрлэх, нөөц зам, гүүрний судалгаанд тодотгол хийх, нэрвэгдэгсдэд тусламжийн бараа материал тээвэрлэн хүргэх, гамшгийн голомтоос хүн ам, эд хөрөнгө, түүх дурсгалын үнэт зүйлсийг нүүлгэн шилжүүлэх, бусад шаардлагатай тээврийн үйлчилгээг үзүүлэх,<br>- Аймгийн Онцгой комиссыг мэдээ, мэдээллээр хангах<br>- Орон нутгийн онцлогт тохируулан нэмэлт өөрчлөлт хийж болно. | Зам, тээврийн алба |

| | | |
|---|---|---|
| 5. | -Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангуулах чиглэлээр холбогдох аж ахуй нэгж байгууллагатай гэрээ байгуулах<br>-Хүнсний бүтээгдэхүүний хангалт, тэдгээрийн тээвэрлэлтийг оновчтой зохион байгуулах ажлыг хэрэгжүүлэх,<br>-Үр тариа, төмс, хүнсний ногоо, тэдгээрийн нутагшсан сорт, бэлчээрийн ургамлын хортон шавж, биологийн өвчлөлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах<br>-Малчдыг даатгалд хамруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, сургалт сурталчилгааг зохион байгуулах<br>-Ган, зудын эрсдэлийн үнэлгээг үндэслэн малчид, тариаланчдад урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах, зөвлөмж хүргэх<br>-Сумдын гамшгийн нөөцийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, удирдлага зохицуулалтаар хангах, хяналт тавих<br>-Бэлчээрийн зохион байгуулалт, мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэлийн талаар нэгдсэн мэдээллээр хангах, ган, зудын аюулаас мал сүргийг хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах<br>-Бэлчээрийн болон таримал ургамал, ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамлаас хамгаалах, түүнтэй тэмцэх, хорио цээр тогтоох, хяналт тавих<br>-Аймгийн хэмжээнд ажиллаж буй хүнсний агуулах, зоорийн судалгаанд тодотгол хийж, гамшгийн үед дайчлан гаргах ажлыг зохион байгуулах,<br>- Аймгийн Онцгой комиссыг мэдээ, мэдээллээр хангах<br>- Орон нутгийн онцлогт тохируулан нэмэлт өөрчлөлт хийж болно. | Хүнс, хөдөө аж ахуйн алба |
| 6. | -Аймаг, сумын хэмжээнд барилгын насжилт, барилга байгууламжийн ашиглалтын төлөв байдалд үнэлгээ, паспортжуулалт хийх, хүн амд учирч болзошгүй эрсдэлийг тооцоолох, зардлыг шийдвэрлүүлэх<br>-Гамшгийн үед ашиглах барилга байгууламж, зам гүүр, машин механизм, тээврийн хэрэгслийн байршил, хүчин чадлын судалгаанд тодотгол хийж, тэдгээрийг дайчлан гаргах,<br>-Бүх төрлийн байр зүйн болон план зургаар хангах, гамшгийн үед аймгийн Онцгой комиссын даргын ажлын болон шийдвэрийн зургийг боловсруулахад дэмжлэг үзүүлэх,<br>-Хүчитгэх шаардлагатай барилга, байгууламжийн судалгаанд тодотгол хийж, хүчитгэл хийх арга хэмжээг үе шаттай зохион байгуулах,<br>-Үерийн хамгаалалт, далан сувгийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, цэвэрлэгээ, үйлчилгээ хийх хуваарийг хийж аймгийн Засаг даргаар батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих<br>-Гамшгийн үед орон гэргүй болсон иргэдийг түр орон байраар хангах боломжтой барилга байгууламжийн судалгаанд тодотгол хийж, холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах,<br>- Аймгийн Онцгой комиссыг мэдээ, мэдээллээр хангах<br>- Орон нутгийн онцлогт тохируулан нэмэлт өөрчлөлт хийж болно. | Барилга, хот байгуулалт, зураг зүйн алба |
| 7. | -Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиог төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хүн амд зарлан мэдээлэх ажлыг шуурхай зохион байгуулах<br>-Мэдээлэл, харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийг нөхөн сэргээх, техник хэрэгслийн гэмтэл саатлыг арилгах, нөхөн сэргээх, кибер халдлагаас урьдчилан сэргийлэх, хэвийн ажиллагааг зохион байгуулах | Мэдээлэл, харилцаа холбооны алба |

| | | |
|---|---|---|
| | -Гамшгийн үед харилцаа холбоог бүх төрлийн сувгаар зохион байгуулж, мэдээ мэдээллийг саадгүй дамжуулах нөхцөлийг бүрдүүлэх, тоног төхөөрөмжийн тасалдалгүй, хэвийн ажиллагааг хангах, мэдээллийн технологийн шинэлэг үйлчилгээг нэвтрүүлэх, оновчтой шийдлийг зохион байгуулах<br>-Гамшгийн үед харилцаа холбоо, мэдээллийн технологийн систем, сүлжээг хууль тогтоомжийн дагуу дайчлан гаргах,<br>-Харилцаа холбоо, мэдээллийн технологийн суурь дэд бүтэц, түүний нөөц сувагчлал, нөхөн хангалтыг хийх<br>- Гамшгийн голомтод ажиллах Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн харилцан ажиллагаа, холбоо зохион байгуулалтыг хангах,<br>- Аймгийн Онцгой комиссыг мэдээ, мэдээллээр хангах<br>- Орон нутгийн онцлогт тохируулан нэмэлт өөрчлөлт хийж болно. | |
| 8. | -Гамшгийн үед онц чухал объектуудыг эрчим хүчээр тасралтгүй хангах<br>-Түлш, эрчим хүчний үйлдвэрүүдийг техникийн үүдэлтэй ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах<br>-Эрчим хүчний зохицуулалт, цахилгаан эрчим хүчний хангалтад хяналт тавих, хязгаарлах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх<br>-Нөөц цахилгааны эх үүсвэрийн судалгаанд тодотгол хийх, бэлэн байдлыг хангах<br>Гамшгийн үед эрчим хүч, дулааны тасалдал, гэмтлийг шуурхай арилгах ажлыг зохион байгуулах<br>Гамшгийн үед эрчим хүч, дулаанаар хангах ажиллагаанд шаардагдах дайчлан гаргах хүч хэрэгсэлийн судалгаанд тодотгол хийх,<br>- Аймгийн Онцгой комиссыг мэдээ, мэдээллээр хангах<br>- Орон нутгийн онцлогт тохируулан нэмэлт өөрчлөлт хийж болно. | Түлш, эрчим хүчээр хангах алба |
| 9. | -Шатахуун түгээх станцуудад гамшгийн нөөцийг бүрдүүлэх, тооцоо судалгааг гаргах, хяналт тавих<br>-Гамшгийн үед ашиглах шаардлагатай хүн хүч, техник, тоног төхөөрөмжийн судалгаа гаргах, бэлэн байдлыг хангуулах<br>-Уурхайн уулын үйлдвэрийн ослын голомтод ажиллах бүлгүүдийн бэлэн байдлыг хангуулах<br>-Гамшгийн үед иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад ашиглах нүүрсээр хангах арга хэмжээг зохион байгуулах, нөөцийг бүрдүүлэх<br>- Аймгийн Онцгой комиссыг мэдээ, мэдээллээр хангах<br>- Орон нутгийн онцлогт тохируулан нэмэлт өөрчлөлт хийж болно. | Байгаль орчин уул уурхайн алба |
| 10. | -Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, дархлаажуулах, халдварын голомт дахь мал, амьтанд үзлэг тандалт хийж оношийг тогтоох, тусгаарлах, хязгаарлалт хорио цээрийн дэглэм тогтоох, ариутгал, халдваргүйтгэлийн арга хэмжээг холбогдох дүрэм, журам, заавар, стандартын дагуу авч хэрэгжүүлэх<br>-Мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах, цацраг идэвхт болон химийн хорт бодисоор хордсон талбай, халдварт өвчний голомт, голомтод байсан хүн, техник хэрэгсэлд ариутгал, халдваргүйтгэл, цэвэрлэгээ хийх<br>- Аймгийн Онцгой комиссыг мэдээ, мэдээллээр хангах<br>- Орон нутгийн онцлогт тохируулан нэмэлт өөрчлөлт хийж болно. | Мал эмнэлгийн алба |
| 11. | -Гамшгийн үед бүх шатны боловсролын байгууллагын дотуур байранд амьдарч буй суралцагчдын эрүүл мэнд, хоол хүнс, аюулгүй байдал, хүүхэд хамгааллын асуудалд анхаарах, цахим | Боловсролын алба |

| | | |
|---|---|---|
| | сургалт, мэдээллийг тасралтгүй зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлэн ажиллах<br>-Гамшгийн үед боловсролын байгууллагын барилга байгууламжийг түр орон байраар ашиглахад дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах<br>- Салбарын тогтвортой байдлыг хангах зохион байгуулалтын арга хэмжээ авах<br>- Аймгийн Онцгой комиссыг мэдээ, мэдээллээр хангах<br>- Орон нутгийн онцлогт тохируулан нэмэлт өөрчлөлт хийж болно. | |
| 12. | - Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34, 51 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасныг хэрэгжүүлэх;<br>- Байгууллагын аюулгүй байдлыг тогтмол шалгах, энэ чиглэлээр холбогдох албан тушаалтны томилох;<br>- Гамшгийн үед байгууллагын үйл ажиллагаа хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэх;<br>- Тусгай зориулалтын мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний бэлэн байдлыг хангуулах сургаж дадлагажуулах, холбогдох байгууллагатай мэдээ мэдээлэл солилцох.<br>- Аймгийн Онцгой комиссыг мэдээ, мэдээллээр хангах<br>- - Орон нутгийн онцлогт тохируулан нэмэлт өөрчлөлт хийж болно. | Хуулийн этгээд |
| 13. | - Салбарын тогтвортой байдлыг хангах зохион байгуулалтын арга хэмжээ авах<br>- Аврах, сэргээн босгоход шаардлагатай төсөв, зардлыг тооцоолох<br>- Гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэж буй аврагчид, ажилтан алба хаагч болон иргэдэд хоол хүнс, ундны ус, дулаан хувцас, түр орон байраар хангах<br>- Аймгийн Онцгой комиссыг мэдээ, мэдээллээр хангах<br>- Орон нутгийн онцлогт тохируулан нэмэлт өөрчлөлт хийж болно. | Санхүү нөөц хангалтын алба |
| 14 | Гамшгаас хамгаалах албадын чиг үүргийг орон нутгийн онцлогт тохируулан нэмж тусгах | |

**2.4. Гамшгаас хамгаалах сургалт:**

2.4.1. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэгт заасан сургалтыг тухайн шатны Засаг дарга, Онцгой байдлын газар, Олон улсын байгууллагатай хамтран зохион байгуулна.

| д/д | Зохион байгуулах сургалт, арга хэмжээ | Хугацаа | Хэрэгжүүлэх байгууллага | Хамтран хэрэгжүүлэх |
|---|---|---|---|---|
| 1. | Гамшгаас хамгаалах иж бүрэн болон команд штабын сургууль (Засаг даргын баталсан хуваарийн дагуу жилд 2-оос доошгүй сум, 1-ээс дээш албанд) зохион байгуулах | Жилдээ | Аймгийн ЗДТГ, ОБГ | АОК, СОК |
| 2. | Гамшгаас хамгаалах сайн дурын хэсэгт сургалт, дадлага зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх | Тухай бүр | ОБГ | Улаан загалмайн хороо |
| 3. | Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагууд суралцагчдын | Хуваарийн дагуу | Боловсролын алба | ОБГ |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | насны онцлогт тохирсон сургалтыг үе шаттай зохион байгуулж, гамшгаас хамгаалах мэдлэг дадал эзэмшүүлэх | | | |
| 4. | Хуулийн этгээд ажилтан, алба хаагч нарын гамшгаас хамгаалах сургалтыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх | Тухай бүр | ОБГ | ААНБ |
| 5. | Иргэн, хуулийн этгээдэд зохион байгуулсан гамшгаас хамгаалах сургалтын дүн мэдээг Онцгой байдлын газарт хүргүүлэх | Улирал бүр | Сумдын ЗДТГ | |

**2.5. Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах:**

2.5.1. Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагууд бэлэн байдлыг хангах дараах нийтлэг арга хэмжээг хэрэгжүүлнэ:

| № | Бэлэн байдлыг хангах арга хэмжээ | Хугацаа | Хэрэгжүүлэх байгууллага | Хамтран хэрэгжүүлэх |
|---|---|---|---|---|
| 1. | Гамшгийн хариу арга хэмжээг зохион байгуулах томилгоот хүч хэрэгсэл (хүн, техник, багаж, тоног төхөөрөмж, зэвсэглэмж, хамгаалах хэрэгсэл)-ийн судалгааг гаргах, тодотгох, нэгдсэн мэдээллийн санд бүртгэх, бэлэн байдлыг хангуулах | Жилд 2 удаа | ГХА, МА | ОБГ |
| 2. | Харилцаа холбоо, зарлан мэдээлэх хэрэгслийн бэлэн байдлыг хангуулах | Тухай бүр | ГХА | ОБГ |
| 3. | Үүрэн холбоо, интернетийн сүлжээний хэрэгслийн бэлэн байдлыг хангах боломж бүрдүүлэх | Тухай бүр | Мэдээлэл, харилцаа холбооны алба | ГХА |
| 4. | Гамшгийн үед ашиглагдах хүнс, бараа материалын нөөцийн судалгааг гаргаж, гэрээ байгуулж, хэрэгжилтийг хангах | Жил бүр | ХХААА | АОК, СОК, ААНБ |
| 5. | Гамшгийн үед ашиглагдах шатах тослох материалын нөөцийн судалгааг гаргаж, гэрээ байгуулж, хэрэгжилтийг хангах | Жил бүр | Эрчим хүчний алба | АОК |
| 6. | Гамшгийн үед ашиглагдах гэр, майхан, зөөврийн сууц, бусад нөөцийг бүрдүүлэх, нэмэгдүүлэх, хадгалалт, бүртгэл тооцоог хийж, хяналт тавих | Жил бүр | Аймаг, сумдын ЗДТГ | ГХА, МА |
| 7. | Дайчлан гаргах хүч хэрэгслийн тодотгол хийх, бэлэн байдлыг хангуулах | I улирал | ЗДТГ | ГХА, ОБГ |
| 8. | Томилгоожсон ажилтан, алба хаагчдыг хүн нэг бүрийн хамгаалах хувцас хэрэглэл, хээрийн үүргэвчээр хангах | Тухай бүр | Сумдын ЗДТГ | ГХА, МА |
| 9. | Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2023 оны А/383 дугаар тушаалаар батлагдсан “Гамшгаас хамгаалах бэлэн байдлын хангах, үзлэг явуулах, үнэлэх журам”-ын хэрэгжилт, биелэлтийг хангуулах, үнэлж дүгнэх | Хуваарийн дагуу | ОБГ | ГХА, МА |

| | | | |
|---|---|---|---|
| 10 | - Гамшгийн үед өөрийгөө болон бусдыг аврах, анхны тусламж үзүүлэх чадвар эзэмших;<br>- Аюулгүйн талбай, түр цугларах цэг, түр амьдрах байрныхаа талаар мэдлэг эзэмших;<br>- Мэргэжлийн ангид томилогдсон бүрэлдэхүүн гамшгийн үед холбогдох хариу арга хэмжээг хэрэгжүүлэх чадвар эзэмших; | Жил бүр | Ажилтан, алба хаагчид |

## ГУРАВДУГААР БҮЛЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

### 3.1. Гамшгийн үеийн зохион байгуулалтын арга хэмжээ

| д/д | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хугацаа | Хэрэгжүүлэх албан тушаалтан | Дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах албан тушаалтан |
|---|---|---|---|---|
| 1. | Аймгийн Онцгой комиссын гишүүдэд зарлан мэдээллийг шуурхай хүргэх | Ц+01:30 | ОБГ | АОК-ын гишүүд |
| 2. | Үүссэн нөхцөл байдлын талаар мэдээ, мэдээллийг цуглуулах, нөхцөл байдлыг үнэлэх | Нэн даруй | АОК-ын гишүүд | ГХА, МА, СОК |
| 3. | Аймгийн Онцгой комиссыг хуралдуулах, шийдвэр гаргах | Нэн даруй | АОК-ын дарга | АОК-ын гишүүд |
| 4. | Аймгийн Шуурхай штабыг идэвхижүүлэх | Шийдвэрийн дагуу | АОК-ын дарга | АОК-ын гишүүд |
| 5. | МУ-ын Засгийн газар, УОК-ын шийдвэр, үүрэг чиглэлийг хэрэгжүүлж, биелэлтийг тайлагнах | Тухай бүр | АОК, ШШ | СОК, СШШ, ГХА |
| 6. | Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийг удирдлага, зохицуулалтаар хангаж, байгууллагуудын харилцан ажиллагааг уялдуулан зохицуулах | Тухай бүр | АОК-ын ШШ | ГХА, МА, ААНБ |
| 7. | Орон нутгийн нөөцийн хуваарилалтыг зохион байгуулах | Тухай бүр | АОК | ГХА, МА, ААНБ |
| 8. | Томилгоожсон хүч хэрэгслийг гамшгийн голомтод хуваарилах | Тухай бүр | АОК-ын ШШ | Сумдын онцгой комиссын дарга |
| 9. | Хүч хэрэгслийг дайчлах шийдвэр гаргах | Тухай бүр | АОК-ын дарга | АОК-ын ШШ |
| 10. | Хүч хэрэгслийг дайчлан гаргах арга хэмжээг удирдан зохион байгуулах | Тухай бүр | АОК-ын ШШ | СОК, ГХА |
| 11. | УОК-оос шаардлагатай тусламж, дэмжлэгийг хүсэх | Тухай бүр | АОК-ын дарга | Аймгийн шуурхай штабын гишүүд |

### 3.2. Гамшгаас хамгаалах удирдлага зохион байгуулалтын бүтэц




### 3.3 Гамшгийн үеийн удирдлага зохицуулалт

3.3.1. Аймгийн Онцгой комиссын Шуурхай штаб нь Улсын Онцгой комиссын даргын 2025 оны 05 дугаар тушаалаар баталсан “Улсын Онцгой комиссын шуурхай штабын ажиллах журам”-ын дагуу ажиллана.

3.3.2. Гамшгийн үед удирдлагаар хангах, нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлэх байгууллага:

| д/д | Аюулт үзэгдэл, ослын төрөл | Удирдан зохицуулах | Зохион байгуулж хэрэгжүүлэх | Дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах алба, байгууллага |
|---|---|---|---|---|
| 1 | Газар хөдлөлт | | АОК-ын ШШ | Гамшгаас хамгаалах алба, ерөнхий, тусгай зориулалтын мэргэжлийн анги, ТЦбХСБ, сайн дурын хэсэг, иргэн, хуулийн этгээд |
| 2 | Хүний гоц халдварт өвчин | | Эрүүл мэндийн алба | Эрүүл мэндийн алба, Хэв журам сахиулах алба, Сумдын онцгой комисс |
| 3 | Ган | АОК, ОБГ | Хүнс, хөдөө аж ахуйн алба | Хэв журам сахиулах алба, Цаг, уурын болон цацраг, химийн аюулыг үнэлж мэдээлэх алба, Сумдын онцгой комисс |
| 4 | Зуд | | Хүнс, хөдөө аж ахуйн алба | Хэв журам сахиулах алба, Хөдөлмөр нийгмийн хамгаалалтын алба, Эрүүл мэндийн алба, Цаг, уурын болон цацраг, химийн аюулыг үнэлж мэдээлэх алба, Сумдын онцгой комисс |
| 5 | Хүчтэй цасан болон шороон шуурга | | АОК-ын ШШ | Цаг, уурын болон цацраг, химийн аюулыг үнэлж мэдээлэх алба, Эрүүл мэндийн алба, |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | Сумдын онцгой комисс, Хүнс, хөдөө аж ахуйн алба, Хэв журам сахулах алба, Түлш, эрчим хүчээр хангах алба |
| 6 | Үер | | Барилга, хот байгуулалт, зураг зүйн алба | Барилга, хот байгуулалт, зураг зүйн алба, Эрүүл мэндийн алба, Цаг, уурын болон цацраг, химийн аюулыг үнэлж мэдээлэх алба, Хэв журам сахиулах алба, Сумдын онцгой комисс |
| 7 | Мал амьтны гоц халдварт өвчин | | Мал эмнэлгийн алба | Хэв журам сахиулах алба, Цаг, уурын болон цацраг, химийн аюулыг үнэлж мэдээлэх алба, Сумдын онцгой комисс |
| 8 | Ой, хээрийн түймэр | | АОК-ын ШШ | ТЦбХСБ, Цаг, уурын болон цацраг, химийн аюулыг үнэлж мэдээлэх алба, Хэв журам сахиулах алба, Ойн санг гэрээгээр эзэмшигч ААНБ, Сумдын онцгой комисс |
| 9 | Цацраг идэвхт, химийн хорт болон аюултай бодис алдагдах | | Цаг, уурын болон цацраг, химийн аюулыг үнэлж мэдээлэх алба | ТЦбХСБ, Эрүүл мэндийн алба, Цаг, уурын болон цацраг, химийн аюулыг үнэлж мэдээлэх алба, Хэв журам сахиулах алба |

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ ДАМЖУУЛАХ

**4.1. Гамшиг, аюулт үзэгдэл, ослын мэдээллийг байгууллагуудад дамжуулах:**

4.1.1.Онцгой байдлын газар гамшиг, аюулт үзэгдэл, ослын тохиолдлын мэдээллийг Онцгой комиссын шуурхай штаб, Бүсийн төв, Онцгой байдлын ерөнхий газрын Ажиллагааны удирдлагын газар, Гал түймэртэй тэмцэх газар, 119 дүгээр анги, аймгийн Онцгой комиссын дарга, гамшгаас хамгаалах орон нутгийн албад шат дараалан дамжуулна.

4.1.2. Онцгой байдлын салбар, нэгжгүй суманд тохиолдсон гамшиг, аюулт үзэгдэл, ослын тохиолдлын мэдээллийг сумын Онцгой комиссоос аймгийн Онцгой байдлын газарт мэдээлнэ.

4.1.3. Мэдээлэл, харилцаа холбооны алба нь зарлан мэдээллийн сүлжээг байнгын бэлэн байдалд байлгаж, гамшгийн үед гарч болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцож чухал шаардлагатай тоног төхөөрөмжийн нөөц / сансрын холбоо, радио холбоо, сүлжээ үүсгэгч /-ийг бүрдүүлэх, түүний байршлыг өөрчлөх, түр зогсоох үед Онцгой байдлын газарт урьдчилан мэдэгдэнэ. /МУ-ын ЗГ-ын 2011 оны 339 дүгээр тогтоолын 4.2/

4.1.4. Аймаг, сумын нутаг дэвсгэрт буюу түүний зарим хэсэгт үүссэн болон үүсэж болзошгүй гамшгийн үед орон нутгийн гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн аймаг, сумын Засаг даргын шийдвэрээр зарлан мэдээллийн бүх хэрэгслээр дамжуулах бөгөөд гамшгийн нөхцөл байдлаас шалтгаалан зарлан мэдээллийн хэрэгсэл байхгүй, эсхүл гэмтэл гарч сэргээх боломжгүй болсон тохиолдолд аймгийн гамшгаас хамгаалах албад төлөвлөгөөнд тусгасаны дагуу бие холбоочин мэдээллийг дамжуулна. / МУ-ын ЗГ-ын 2011 оны 339 дүгээр тогтоолын 4.3.2/

4.1.5. Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудтай Онцгой байдлын газар харилцан ажиллагааны “Чиглэлийн төлөвлөгөө”-нд тусгагдсаны дагуу холбоо зохион байгуулалтыг хэрэгжүүлнэ.

4.1.7. Аюул өнгөрсөн тухай мэдээллийг холбогдох мэргэжлийн байгууллагын санал дүгнэлтийг үндэслэн мэдээлэл, харилцаа холбооны алба бүх төрлийн мэдээллийн хэрэгслээр дамжуулна.

**Гамшиг, аюулт үзэгдэл, ослын мэдээллийг дамжуулах бүдүүвч**




**4.2. Гамшиг, аюулт үзэгдэл, ослын мэдээллийг иргэдэд дамжуулах:**

4.2.1. Гамшгийн зарлан мэдээллийг дараах бүдүүвчийн дагуу дамжуулна:

4.2.1.1. Газар хөдлөлтийн аюулын тухай анхааруулах бүдүүвч:




4.2.1.2. Үер, хүчтэй салхи шуургын тухай анхааруулах бүдүүвч:




4.2.3. Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийг сирень дохио ашиглан иргэд, олон нийтэд хүргэхдээ аймгийн төв Сайнцагаан сумын хэмжээнд АОК-ын дарга, АОК-ын орлогч даргын шийдвэрээр харилцаа холбооны албанаас томилогдсон алба хаагч дуугаргана.

Сумдын хэмжээнд СОК-ын дарга, ЗДТГ-ын даргын шийдвэрээр томилгоот алба хаагч зарлан мэдээллийн сирень дохиог дуугаргана.

4.2.4. Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийг сирень дохиогоор дамжуулахдаа түгшүүрийн дохиог:

- Гамшгийн үед 30 секунд үргэлжлэх хугацаатайгаар 1 удаа дуугаргах ба давталтайгаар.
- Сургалт, дадлагын үеэр Нэгдүгээр, Хоёрдугаар, Гуравдугаар сургалтын дохиог 120 секундын турш тасралтгүй цацаж дундаа 60 секунд завсарлага авна. /MNS6980:2022 Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх үйл ажиллагааны стандарт 1 дүгээр хавсралт/

4.2.5. Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн зурвасаар урсах бичвэрийн үсгийн фонт нь ердийн ”Arial“ байна. Фонтын үсгийн өндөр нь 18~20 хэмжээтэй байна. Бичвэрийн урсан өнгөрөх хурд нь үзэгч уншиж гүйцэхүйц буюу нэг минутад 250~275 тэмдэгт буюу 50~55 үг байна.

4.2.6. Гамшгийн аюулын тухай зарлан мэдээлэл дамжуулсан үед онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь харьяа салбар нэгж, олон нийтийн болон орон нутгийн радио, телевиз, мэдээлэл, харилцаа холбооны албан мэдээлэл дамжуулах үйл ажиллагаанд хяналт тавьж, шуурхай удирдлагаар хангаж ажиллана.

## ТАВДУГААР БҮЛЭГ. ГАМШГИЙН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ

### 5.1. Гамшгийн үеийн удирдлага, зохицуулалт

5.1.1. Аймгийн онцгой комисс удирдлага зохицуулалтаар хангаж гамшгийн үед эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд хүч хэрэгслийг нэгдсэн удирдлага зохицуулалтаар хангана.

5.1.2. Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагууд Онцго байдлын газартай байгуулсан “Харилцан ажиллагааны чиглэлийн төлөвлөгөө”-ний хавсралтаар баталсан хүч

хэрэгслээр гамшгаас эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээнд дэмжлэг үзүүлж оролцоно.

5.1.3. Аймгийн Онцгой комисс нь гамшгийн үед АОК-ын ажиллах журмын дагуу удирдлага зохицуулалтаар хангаж холбогдох арга хэмжээг хэрэгжүүлж ажиллана.

**5.2. Газар хөдлөлтийн гамшгийн хариу арга хэмжээ**

5.2.1. Газар хөдлөлтийн эрсдэлийн аюулын түвшин тухайн аймгийн нутаг дэвсгэрийн 1,595.8 км² /2.2%/ талбай нь дунд түвшинд, 2,1461.7 км² /28.7%/ нь их, 51,632 км² /69.1%/ нь маш их түвшинд байна. Аймгийн хэмжээнд нийт 19 трансформаторын станц байгаагаас 1 буюу 5.3% нь дунд, 17 буюу 89.5% нь их, 1 буюу 5.3% нь маш их түвшинд байна. Аймгийн хэмжээнд нийт 11 агуулах байгаагаас бүгд их түвшинд байна. Аймгийн хэмжээнд нийт 248 авто замын ус дамжуулах хоолой байгаагаас бүгд их түвшинд байна. Аймгийн хэмжээнд нийт 51 боловсролын байгууламж байгаагаас 1 буюу 2% нь бага, 16 буюу 31.4% нь дунд, 13 буюу 25.5% нь их, 21 буюу 41.2% нь маш их түвшинд байна. Харилцаа холбооны шугам бага түвшинд 114.1км буюу 9.1%, дунд түвшинд 747.2км буюу 58.7%, их түвшинд 422.6км буюу 32.2%-тай үнэлэгдсэн. Улсын чанартай авто зам дунд түвшинд 33.5км буюу 4.2%, их түвшинд 251.1км буюу 29.3%, маш их түвшинд 538.4км буюу 66.5%-тай үнэлэгдсэн. Эрчим хүчний шугам бага түвшинд 17.1км буюу 1.3%, дунд түвшинд 317.5км буюу 24.3%, их түвшинд 939.7км буюу 72.8%, маш их түвшинд 19.7км буюу 1.5%-тай үнэлэгдсэн.

5.2.2 Дундговь аймгийн Сайнцагаан сум /аймгийн төв/ газар хөдлөлтийн гамшигт өртсөн тохиолдолд гамшигт нэрвэгдээгүй аймгийн Онцгой комиссын гишүүд Нутгийн захиргааны удирдлагын байрны урд талбайд нэн яаралтай цугларч, Улсын онцгой комиссоос шуурхай удирдлагын бүлэг, дэмжлэг ирэх хүртэлх хугацаанд гамшгийн хариу арга хэмжээг шуурхай удирдан зохион байгуулах арга хэмжээг эхлүүлнэ.

5.2.3. Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн газар хөдлөлтийн гамшигт нэрвэгдээгүй бол байгууллагын аюулгүйн цугларах талбайд цугларч гамшгаас хамгаалах төлөвлөгөөний дагуу гамшгийн хариу арга хэмжээг шуурхай хэрэгжүүлнэ.

5.2.4 Газар хөдлөлтийн гамшигт өртөөгүй сумдын онцгой комисс, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн газар хөдлөлтийн гамшгийн голомтод хүн хүч, техник хэрэгслийн нөөцийг бэлтгэж аймгийн Онцгой комиссын шийдвэрээр дэмжлэг үзүүлнэ. Шаардлагатай тохиолдолд шууд дэмжлэг үзүүлэх арга хэмжээг эхлүүлж болно.

5.2.5 Бусад аймаг, нийслэл газар хөдлөлтийн гамшигт өртсөн тохиолдолд Улсын Онцгой комисс, Аймгийн онцгой комиссын шийдвэрээр дэмжлэг үзүүлэх хүн хүч, техник хэрэгслийн нөөцийг бүрдүүлж, дотоодын хүмүүнлэгийн тусламжийг зохион байгуулан дэмжлэг үзүүлэх арга хэмжээг шуурхай зохион байгуулна.

5.2.6. Газар хөдлөлтийн гамшгийн үед хэрэгжүүлэх арга хэмжээ

| № | Хариу арга хэмжээ | Хэрэгжүүлэх арга зам | Хугацаа | Удирдан зохицуулах чиглэл хариуцсан байгууллага | Дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах байгууллага |
|---|---|---|---|---|---|
| 1 | Зарлан мэдээлэл хүргэх | Сирень дохиог ажиллуулах | Ц+00:05 | МХХА | ОБГ |
| 2 | | Биет холбоочноор мэдээ хүргүүлэх | Ц+01:00 | МХХА | АОК |
| 3 | Засаг дарга бөгөөд Онцгой комиссын даргад мэдээлэх | Газар хөдлөлт болсон тухай мэдээлэл өгөх | Ц+00:10 | ОБГ | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4 | Аймгийн Онцгой комиссын гишүүд, Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийг цуглуулах | АОК-ын бүрэлдэхүүнийг бүртгэх | Ц+00:30 | ГХА, МА-ийн дарга нар | ОБГ |
| 5 | Онцгой комиссын гишүүдэд мэдээлэл дамжуулах | Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг идэвхжүүлнэ | Ц+00:30-аас | ОБГ | |
| 6 | Шуурхай үнэлгээ хийх | Харилцаа холбоо тасраагүй тохиолдолд иргэдээс дуудлага мэдээллийг хүлээн авна | Ц+00:30-аас | АОК | МХХА |
| 7 | | Биетээр тандалт хийж мэдээлэл цуглуулах | Ц+00:30-аас | АОК | ГХА, МА |
| 8 | | Агаараас нөхцөл байдлыг тандах | Ц+00:20-аас | АОК | ОБГ |
| 9 | Онцгой комиссыг яаралтай хуралдуулах | Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг идэвхижүүлэх | Ц+00:30-аас | АОК | ОБГ |
| 10 | | Шуурхай штабыг байгуулан 24 цагын жижүүрээр гаргах, томилгоо хийх | Ц+01:00-аас | АОК | СОК, ОБГ |
| 11 | | Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийг ажиллагаанд оруулах, хүч хэрэгслийг хуваарилах | Ц+01:00-аас | АОК | СОК, ОБГ |
| 12 | Иргэдийг үүссэн нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэх мэдээллээр хангах | Бүх нийтийн харилцаа холбоо, олон нийтийн сүлжээгээр | Ц+01:00-аас | Сургалт сурталчилгаа ны алба | АОК, СОК |
| 13 | Эрэн хайх, аврах ажиллагаа зохион байгуулах | Нурсан барилгад нэрвэгсдийг гаргах эрэн хайх, аврах | Ц+00:10-аас | ОБГ | СОК, ГХА, МА |
| 14 | Гал түймэр унтраах, тархалтыг зогсоох | Газар хөдлөлтөөс үүдэлтэй объектын гал түймрийг унтраах, дэлбэрэлтээс сэргийлэх | Ц+00:40-аас | ОБГ | СОК, ГХА, МА |
| 15 | Хэв журам сахиулах | Голомтын бүсэд хамгаалалт тогтоох, нийтийн | Ц+00:05-аас | ХЖСА | Сумын ЗДТГ |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | аюулгүй байдлыг хангах | | | |
| 16 | | Төв болон туслах замуудыг чөлөөлж, гадны хөдөлгөөнийг хязгаарлах | Ц+24:00-аас | ХЖСА | ЗТА |
| 17 | | Улсын онц чухал объектуудыг хамгаалалтад авах, хяналтыг сайжруулах | Ц+01:00-аас | ХЖСА | ДЦ |
| 18 | Нэрвэгдэгсдэд туслах, эмнэлгийн яаралтай тусламж | Аюулгүй талбайд иргэдийг бүртгэх, эмнэлгийн анхны тусламж үзүүлж, түр хоргодох газарт тээвэрлэх ажлыг зохион байгуулах | Ц+00:15-аас | ЭМА | ЭМТҮМА |
| 19 | Дэд бүтцийг сэргээх | Цахилгаан | Ц+01:30-аас | ЭХА | ЦХМА |
| 20 | | Дулаан, цэвэр бохирын шугам | Ц+06:00-аас | ЭХА | ДХМА |
| 21 | | Харилцаа холбоо | Ц+12:00-аас | МХХА | МА |
| 22 | Зам, гүүрний саадыг арилгах | Төв болон туслах замын нурангийг цэвэрлэх | Ц+03:00-аас | ЗТА | СОК |
| 23 | Хээрийн эмнэлэг дэлгэх | Нэрвэгдсэн иргэдийг хээрийн эмнэлэг рүү зөөвөрлөх | Тухай бүр | ЭМА | ЗТА |
| 24 | | Бэртэж гэмтсэн иргэдийг анхны тусламж үзүүлж эрэмбэлэх | Тухай бүр | ЭМА | СОК |
| 25 | | Нэрвэгдэгсдэд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх | Ц+12:00-аас | ЭМА | СОК |
| 26 | Дайчилгааны хангамж | Шаардлагатай хүн хүч, техник хэрэгслийн тооцоог гаргаж нэмэгдүүлэх | Ц+01:00-аас | АЗД | СОК |
| 27 | | Дайчилгаагаар ажиллаж буй техникүүдийг шатахуун, хүмүүсийг хоол хүнсээр хангах | Ц+24:00-дуустал | СОК | ЭХА, ХХААА |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 28 | Хорогдох байраар хангах | Гэр оронгүй болсон иргэдийг хүлээн авах бүртгэх, эрэмбэлэх | Ц+12:00-аас | ХНХА | СОК |
| 29 | Нүүлгэн шилжүүлэх | Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөг идэвхжүүлэх | Ц+02:00-аас | АОК, ГХА, МА | СОК |
| 30 | Нийгмийн халамж, үйлчилгээ | Эмзэг бүлгийн иргэдийг бүртгэж, тусгайлан тусламж үзүүлэх | Ц+06:00-аас | ХНХА | СОК |
| 31 | Тандалтын бүлэг ажиллуулах | Барилга байгууламжийн нуралтаас урьдчилан сэргийлэх | Ц+12:00-аас | Ажлын хэсэг | БХБА |
| 32 | | Химийн хордлогоос урьдчилан сэргийлэх | Ц+12:00-аас | ЦАҮМА | БОА |
| 33 | | Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх | Ц+12:00-аас | ЭМА | МЭА, ЭМТҮМА |
| 34 | Нөхцөл байдлыг дахин үнэлэх | Биетээр тандалт хийж мэдээлэл цуглуулах | Ц+00:30-аас | Ажлын хэсэг | АОК |
| 35 | Ар тал хангалт | Хоол, хүнсний хангалт | Ц+02:00-аас | ХХААА | ААНБ |
| 36 | | Шатахууны хангалт | Тухай бүр | ШХМА | ААНБ |
| 37 | | Хувцас хэрэгслийн хангалт | Тухай бүр | ХНХА | ААНБ |
| 38 | | Шаардлагатай техник хэрэгслийн хангалт | Тухай бүр | ЗТА | БОУУА |
| 39 | | Эм, эмнэлгийн хэрэгслийн хангалт | Тухай бүр | ЭМА | ЭМТҮМА, ААНБ |
| 40 | Хүмүүнлэгийн тусламж зохицуулалт | Ирж буй хандив, тусламжийг хүлээн авах, бүртгэх, хуваарилах | Ц+24:00-аас | Аймгийн ЗДТГ | Ажлын хэсэг |
| 41 | Нас барагсдыг таниулах | Буцалтгүй нэрвэгдэгсдийг хадгалах байрыг бэлтгэх | Ц+72:00-аас | ЭМА | Нэгдсэн эмнэлэг |
| 42 | | Буцалтгүй нэрвэгдэгсдийг зөөвөрлөх ажлыг зохион байгуулах | Ц+72:00-аас | Шүүх шинжилгээний хэлтэс | ЭМА, ЗТА |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 43 | | Цогцос хадгалах, зөөвөрлөх, ар гэрийнхэнд нь хүлээлгэн өгөх | Ц+72:00-аас | | ХЖСА |
| 44 | Ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг зохион байгуулах | Аймгийн хэмжээнд бохирдол үүссэн газарт ариутгал халдваргүйжүүлэлт хийх | Тухай бүр | АОК | ХХААГ, МЭА, ААНБ |
| 45 | Хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааг зохион байгуулах үнэлгээ | Гамшгийн дараах үнэлгээг хийх | Ц+72:00-аас | АОК | Ажлын хэсэг |

## ХОЙШЛУУЛШГҮЙ СЭРГЭЭН БОСГОХ АРГА ХЭМЖЭЭ

| № | Хариу арга хэмжээ | Хэрэгжүүлэх арга зам | Хугацаа | Удирдан зохицуулах байгууллага | Хамтран ажиллах байгууллага | Хэрэгжүүлэх түвшин | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Сум, дүүрэг | Баг, хороо | Иргэн |
| | | Хойшлуулашгүй сэргээн босгох үйл ажиллагааг зохион байгуулах үнэлгээ хийх | Ц+00:00-00:30 | Ажлын хэсэг | ГХА, МА | + | + | + |
| 1 | Шуурхай штабын шийдвэр, удирдлага зохион байгуулалт | Сэргээн босгох үйл ажиллагааг удирдан зохион байгуулах шуурхай штабыг томилох | Ц+00:00-00:30 | АОК | ГХА, МА | + | + | |
| | | Гамшгийн хохирол, сэргээн босгох үйл ажиллагааны хэрэгцээний үнэлгээ хийх | Ц+00:30-дуустал | ШШ | ГХА, МА | + | + | |
| | | Үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, Улсын Онцгой комисст танилцуулах, шийдвэрлүүлэх, үйл ажиллагаанд зохицуулалт хийх | Ц+00:30-72:00 | ШШ | ГХА, МА | + | + | |
| | | Холбогдох хуулийн дагуу онцгой журам тогтоох, мөрдүүлэх | Ц+00:30-дуустал | АОК | ЦГ | + | + | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | Ариутгал, халваргүйжүүлүүлэлт | Нурангийг зайлуулах, байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг бууруулах | Ц+96:00-дуустал | БОГ | ГХА, МА | + | + | |
| | | Орчны бохирдлын шинжилгээ хийх | Ц+120:00-дуустал | БОГ | ЭМГ | + | + | |
| | | Ариутгал халдваргүйжүүлэлтийн хийх | Ц+120:00- | МЭГ | ШШ | + | + | |
| 3 | Сэргээн засварлах ажиллагаа | Бүх шатны боловсролын байгууллагын хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх | Ц+168:00-дуустал | БГ | Ерөнхий боловсролын сургууль, СӨББ | + | + | |
| | | Газар хөдлөлтийн хохирлоос болж эвдэрсэн барилга байгууламжийн эвдрэл гэмтлийн зэрэглэлийг тогтоох, цаашид ашиглах боломжтой барилгыг сэргээн засварлах | Ц+96:00-дуустал | ГХБХБГ | ШШ | + | + | |
| | | Олон нийтийн үйлчилгээний зориулалттай барилга байгууламжийг хүчитгэн бэхжүүлэх | Ц+30 хоног-дуустал | ГХБХБГ | ШШ | + | + | |
| | | Инженерийн хангамжийн байгууламж, тэдгээрийн эх үүсвэрийг сэргээн засварлах | Ц+30 хоног-дуустал | Түлш эрчим хүчний алба | ШШ | + | + | |
| | | Цаашид сэргээн засварлах боломжгүй барилга байгууламжийг буулган талбай чөлөөлөх арга хэмжээ авах | Ц+30хоног-дуустал | АОК | ГХА, МА | + | + | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | Хор уршгийг арилгах үүссэн эрсдэлийг үнэлэх, санхүүгийн зохицуулалт хийх | Газар хөдлөлтийн дараах хойшлуулшгүй сэргээн босголтод шаардагдах зардлыг тооцож, хөрөнгийн тооцоог үнэлж гаргах | Ц+1 жил-дуустал | АЗДТГ-н СТСХ | ШШ | + | + | |
| | | Олон улсын байгууллага, хандивлагч орнуудын тусламж, зээлийн хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах | Ц+96:00-дуустал | АЗДТГ-н СТСХ | ГХА, МА | + | + | |

Аймгууд Гамшгийн эрсдэлийн үнэлгээний тайланд тусгагдсан зөвлөмжийн дагуу дундаас дээш эрсдэлтэй гарсан гамшгийн төрөл тус бүрд хариу арга хэмжээг нарийвчлан орон нутгийн онцлогт тохируулан төлөвлөгөөнд тодотгол хийх.

5.2.7. Газар хөдлөлтийн хариу арга хэмжээний даргын ажлын зургийн төсөл



Даргын ажлын зургийг дээрх зураг дээр боловсруулж цахим холбоосоор шууд ашиглах боломжийг бүрдүүлэх бөгөөд өргөтгөл бүхий зургийг цахим хэлбэрээр архив үүсгэн хадгална.

**5.3. Үерийн хариу арга хэмжээ**

5.3.1. Үерийн эрсдэлийн аюулын түвшин тухайн аймгийн нутаг дэвсгэрийн 23994.9км²/32.1%/ талбай нь маш бага түвшинд, 49217км²/65.8%/ нь бага, 1477.8км²/2.1%/ дунд түвшинд байна. Аймгийн хэмжээнд нийт 19 трансформаторын станц байгаагаас 18 буюу 94.7% нь бага,1 буюу 5.3% нь дунд түвшинд байна. Аймгийн хэмжээнд нийт 11 агуулах байгаагаас бүгд бага түвшинд байна. Аймгийн хэмжээнд нийт 248 авто замын ус дамжуулах хоолой байгаагаас бүгд бага түвшинд байна. Аймгийн хэмжээнд нийт 51 боловсролын байгууламж байгаагаас 15 буюу 29.4% нь маш бага, 14 буюу 27.5% нь бага, 12 буюу 23.5% нь дунд, 10 буюу 19.6% нь их түвшинд байна. Харилцаа холбооны шугам маш бага түвшинд 799.8км буюу 62.9%, бага түвшинд 484.1км буюу 37.1%-тай үнэлэгдсэн. Улсын чанартай авто зам маш бага түвшинд 90.1км буюу 9.5%, бага түвшинд 171.2км буюу 21.2%, дунд түвшинд 51.9км буюу 6.4% ,их түвшинд 509.1 км буюу 62.9%-тай үнэлэгдсэн. Эрчим хүчний шугам маш бага түвшинд 399.1км буюу 31%, бага түвшинд 824.6км буюу 63.5%, дунд түвшинд 70.4км буюу 5.5%-тай үнэлэгдсэн.

<table>
<tr><th rowspan="2">№</th><th rowspan="2"></th><th rowspan="2">Хариу арга хэмжээ</th><th rowspan="2">Хэрэгжүүлэх арга зам</th><th rowspan="2">Хугацаа</th><th rowspan="2">Удирдан зохицуулах байгууллага</th><th rowspan="2">Хамтран ажиллах байгууллага</th><th colspan="3">Хэрэгжүүлэх түвшин</th></tr>
<tr><th>Сум, дүүрэг</th><th>Баг, хороо</th><th>Иргэн</th></tr>
<tr><td>1.</td><td></td><td>Зарлан мэдээллийг хүргэх</td><td>Үерийн нөхцөл байдлын талаар мэдээ, мэдээллийг шуурхай хүргэх</td><td>Ц+00:05</td><td rowspan="3">ОБГ</td><td>АОК-ын дарга, Үерийн гамшгийн үед ажиллах ажлын хэсэг</td><td>+</td><td></td><td></td></tr>
<tr><td>2.</td><td></td><td>Үерийн гамшгийн хариу арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх</td><td>Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах</td><td>Ц+00:20</td><td rowspan="2">Барилга, хот байгуулалтын алба Код-4</td><td>+</td><td></td><td></td></tr>
<tr><td>3.</td><td></td><td>Үерийн гамшгийн тухай дуудлагын талаар шаардлагатай бүх төрлийн мэдээлэл цуглуулах, нэгтгэх</td><td>Үүссэн нөхцөл байдлын талаар мэдээлэл цуглуулах, нөхцөл байдлыг үнэлэх</td><td>Ц+00:20</td><td>+</td><td></td><td></td></tr>
<tr><td>4.</td><td></td><td>Шуурхай хуралдааныг зохион байгуулах</td><td>Үерийн гамшгийн үед ажиллах ажлын хэсгийг хуралдуулах</td><td>Ц+01:00</td><td>ОБГ</td><td rowspan="2">Үерийн гамшгийн үед ажиллах ажлын хэсэг</td><td>+</td><td></td><td></td></tr>
<tr><td>5.</td><td></td><td>Шуурхай штабыг байгуулах</td><td>Голомтын бүсэд шуурхай штабыг байгуулан хариу арга хэмжээ авах</td><td>Ц+02:00</td><td>АОК-ын ШШ</td><td>+</td><td></td><td></td></tr>
</table>

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6. | | Хүч хэрэгслийг тодотгох | Байгууллагын хүч хэрэгслийг тодотгон төвлөрүүлэх | Ц+02:00 | АОК-ын ШШ | Барилга, хот байгуулалтын алба | + | | |
| 7. | | Үүссэн нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэх мэдээллээр хангах | Бүх нийтийн харилцаа холбоо, олон нийтийн сүлжээгээр мэдээллийг дамжуулах | Тухай бүр | | Сургалт, сурталчилгааны алба | + | | |
| 8. | | Өртөж болзошгүй болон өртсөн хүн, мал, эд хөрөнгийг нүүлгэн шилжүүлэх | Үерт өртөж болзошгүй, үерт өрсөн газар орноос нүүлгэн шилжүүлэх хүн, мал, амьтан, эд хөрөнгийн судалгаа, нүүлгэн шилжүүлэх дараалал гаргах | Тухай бүр | | ГХА, МА | + | | |
| 9. | | Нэн тэргүүнд хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх | Хурлаас гарсан шийдвэрийн хэрэгжилтийг хангах хариу арга хэмжээг хэрэгжүүлэх | Тухай бүр | | | + | | |
| 10. | | Хэв журам сахиулах | Голомтын бүсэд хамгаалалт тогтоох, хэв журам сахиулах | Тухай | ЖЖСА | ГХА, МА | + | | |
| 11. | | Бусад арга хэмжээг хэрэгжүүлэх | | | | | | | |
| ХОЙШЛУУЛШГҮЙ СЭРГЭЭН БОСГОХ АРГА ХЭМЖЭЭ | | | | | | | | | |
дугаар сарын 01-ний өдрийн 182 дугаар тогтоолоор батлагдсан "Гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах журам"-ыг удирдлага болгон 8.6 дахь заалтад заасны дагуу зохион байгуулна.

8.1.2. Гамшгийн нөхцөл байдлаас хамаарч аймаг, сумын гамшгаас хамгаалах томилгоот хүч хэрэгсэл хүрэлцэхгүй тохиолдолд нэмэлтээр аймаг, сумын нутаг дэвсгэрт хүч хэрэгсэл дайчлан гаргах ажиллагааг зохион байгуулна.

8.1.3. Хүч хэрэгсэл дайчлан гаргах төлөвлөгөөг Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсэг болгон боловсруулж иргэн, хуулийн этгээдийн өмчлөл, эзэмшилд байгаа барилга байгууламж, нисэх онгоц, нисдэг тэрэг, төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн, бүх төрлийн тээврийн хэрэгсэл, өөрөө явагч машин механизм (даатгалд хамрагдсан байх), нисдэг тэрэг хөөрч, буух талбай, барилга байгууламж, газар, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, стратегийн хүнс, эм, эмнэлгийн хэрэгсэл, газрын тосны бүтээгдэхүүн, сэлбэг хэрэгслийн судалгааг урьдчилан гаргаж, иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулсан байна.

8.1.4. Хүч хэрэгсэл дайчлан гаргах ажиллагаа нь дараах үе шаттай байна;

Гамшгийн өмнө;

Гамшгийн үед;

Гамшгийн дараах үед гэсэн үе шатанд зохион байгуулна.

**8.2. Гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах төлөвлөгөө**

| д/д | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хугацаа | Удирдан зохицуулах | Дэмжлэг үзүүлэх |
|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 |
| Гамшгийн өмнө | | | | |
| 1. | Дайчлан гаргах боломжтой иргэн, хуулийн этгээдийн барилга, байгууламж, газар, хүн, техник, тоног төхөөрөмж, бараа материал, эд хөрөнгийн судалгааг гаргах | Жил бүр | Аймаг, сумдын ОК, ОБГ | ГХА, МА |
| 2. | Дайчилгаа зохион байгуулах штаб, ажлын хэсгийг томилгоожуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээний баримт бичгийн төслийг бэлтгэх | Хэрэгжүүлэх арга хэмжээний дагуу | Аймаг, сумдын ОК, ОБГ | ГХА, МА |
| 3. | Гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах төлөвлөгөөг аймаг, сумдын түвшинд боловсруулж, шаардлагатай судалгаа тооцоог жил бүр шинэчлэн тодотгол хийх | Тухай бүр | Аймаг, сумдын ОК, ГХА | ОБГ |
| 4. | Үүрэг гүйцэтгэх хүч хэрэгслийг гамшиг, аюулт үзэгдэл, ослын голомтод тогтоосон хугацаанд хүргэх зорилгоор нэгтгэн байршуулах объект, талбайг томилгоожуулах | Тухай бүр | ОБГ, БХБЗЗА | ГХА, МА |
| 5. | Үүрэг гүйцэтгэх иргэн, хуулийн этгээдийн бие бүрэлдэхүүнд сургалт, дадлага зохион байгуулах, иж бүрэн болон команд штабын сургууль зохион байгуулах | Жил бүр | ОБГ | Аймаг, сумдын ЗДТГ |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 6. | Дайчлагдан ажиллах тухай зарлан мэдээлэл дамжуулах 3-аас доошгүй сувгийг бэлтгэх, холбоо, зарлан мэдээллийн хэрэгслийн бэлэн байдлыг хангуулах | Тухай бүр | Аймаг, сумдын ОК | ГХА |
| 7. | Дайчилгааны нөөцийг бүрдүүлэн, бүх төрлийн ар тал хангалтын бэлэн байдлыг хангах | Жил бүр | Аймаг, сумдын ОК | ГХА |
| 8. | Дайчлан гаргах боломжтой хүч хэрэгслийн тооцоо, судалгааг гаргах | Жил бүр | Аймаг, сумдын ОК | ГХА |
| 9. | Холбогдох аж ахуйн нэгж, байгууллага, иргэнтэй хамтран ажиллах тухай гэрээ байгуулж, бэлэн байдлыг хангуулан мэдэгдэл хүргэх | Жил бүр | Аймаг, сумдын ОК | ГХА |
| Гамшгийн үед | | | | |
| 10. | Хүч хэрэгсэл дайчлан гаргах үйл ажиллагааг зохион байгуулах шуурхай ажлын хэсгийг гамшгийн нөхцөл байдалд уялдуулан байгуулах | Ц+01:00 Гамшгийн нөхцөл байдлаас хамаарна | Аймгийн ЗДТГ | ОБГ, ГХА, иргэн, хуулийн этгээд |
| 11. | Гамшигт өртсөн газар, орноос нөхцөл байдлын мэдээ мэдээллийг шуурхай цуглуулж, үүссэн гамшгийн нөхцөл байдлыг үнэлэх | Тухай бүр | Аймаг, сумдын Засаг дарга | ОБГ, ГХА, иргэн, хуулийн этгээд |
| 12. | Үүссэн нөхцөл байдалтай уялдуулан шаардлагатай хүч хэрэгслийг тооцох | Ц+01:00, Гамшгийн нөхцөл байдлаас хамаарна | Аймаг, сумдын ОК, шуурхай ажлын хэсэг | ОБГ, ГХА, иргэн, хуулийн этгээд |
| 13. | Гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах шийдвэрийн төсөл, шаардлагатай мэдээлэл бэлтгэж, Шийдвэр гаргах үйл ажиллагааг зохион байгуулах | Тухай бүр | Шуурхай ажлын хэсэг | Аймаг, сумдын ОК |
| 14. | “Хүч хэрэгсэл дайчлан гаргах” шийдвэрийг батлуулах | Тухай бүр | Аймаг, сумдын Засаг дарга | Шуурхай ажлын хэсэг |
| 15. | Дайчлагдан ажиллах хүч хэрэгслийн нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлэх, харилцан ажиллагааг зохион байгуулах | Тухай бүр | Аймаг, сумдын ОК | Шуурхай ажлын хэсэг |
| 16. | Дайчилгаагаар үүрэг гүйцэтгэж байгаа иргэн, хуулийн этгээдийн хүн хүч хэрэгслийн гүйцэтгэх үүрэг, хэрэгжилтэд хяналт тавих | Тухай бүр | ОБГ | Аймаг, сумдын ОК |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 17. | Хүч хэрэгсэл дайчлан гаргах шийдвэрийг холбогдох байгууллага, иргэн, хуулийн этгээдэд хүргэх | Тухай бүр | Аймаг, сумдын ОК | Шуурхай ажлын хэсэг |
| 18. | Дайчлан гаргах үйл ажиллагааны талаар олон нийтэд мэдээлэл хүргэх | Тухай бүр | ХМСА | ГХА |
| 19. | Дайчлан гаргах ажиллагаанд шаардагдах хөрөнгийг шийдвэрлэх | Тухай бүр | Аймаг, сумдын ОК | ГХА |
| 20. | Дайчлагдан ажиллах хүч хэрэгсэлд шаардлагатай хангалтыг тооцох | Тухай бүр | Аймаг, сумдын ОК | ГХА |
| 21. | Хангалтыг хуваарилах, хүргэх | Тухай бүр | Аймаг, сумдын ОК | ГХА |
| 22. | Дайчлагдан ажилласан хүч хэрэгслийн зардлыг нөхөн олгох. | Тухай бүр | Аймаг, сумдын ОК-ын дарга нар | ГХА |
| 23. | Хүч хэрэгслийг томилгоот болон сонгосон газар, оронд татан төвлөрүүлэх | Тухай бүр | Аймаг, сумдын ОК | ГХА |
| 24. | Дайчлагдан ажиллах хүч хэрэгслийг бүртгэх | Тухай бүр | Шуурхай ажлын хэсэг | Аймаг, сумдын ОК, ГХА |
| 25. | Төвлөрсөн хүч хэрэгслийг гамшгийн голомтод хуваарилах | Тухай бүр | Шуурхай ажлын хэсэг | Аймаг, сумдын ОК, ГХА |
| 26. | Хариу арга хэмжээний үеийн аюулгүй байдал, нийтийн хэв журмыг хангах | Тухай бүр | Аймаг, сумдын ОК | ХЖСА |
| Гамшгийн дараа | | | | |
| 27. | Дайчлагдан ажилласан хүн, хүч хэрэгслийг бүртгэх, буцаах ажлыг зохион байгуулах | Гамшгийн дараа | АОК | СОК, ОБГ |
| 28. | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, дүн мэдээг нэгтгэх, үр дүнг тайлагнах; | Гамшгийн дараа | АОК | СОК |
| 29. | Хүч хэрэгсэл дайчлан ажиллуулсан зарцуулсан зардлыг нарийвчлан тооцож олгох асуудлыг шийдвэрлэх | Гамшгийн дараа | АОК | СОК |

8.3. Хүч хэрэгсэл дайчлан гаргах ажиллагаанд харьяа орон нутгийн Засаг дарга хяналт тавина.

8.4. Орон нутгийн гамшгаас хамгаалах алба, ерөнхий зориулалттай мэргэжлийн анги, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын хүч хэрэгсэлд Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг зохион байгуулах.

## ЕСДҮГЭЭР БҮЛЭГ. ХҮМҮҮНЛЭГИЙН ТУСЛАМЖ, ДЭМЖЛЭГ

### 9.1. Хүмүүнлэгийн тусламжийн удирдлага зохицуулалт

9.1.1. Дотоодын хүмүүнлэгийн тусламжийг Гамшгаас хамгаалах тухай хууль, Улсын нөөцийн тухай хууль, Гамшгаас хамгаалах дотоодын хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах журам, Хүмүүнлэгийн багийн бүрэлдэхүүн, түүний ажиллах журмыг удирдлага болгон зохион байгуулна.

9.1.2. Аймаг, сумын онцгой комисс, онцгой комиссын шуурхай штабаас олон улсын хүмүүнлэгийн тусламжийг зохион байгуулахад шаардагдах мэдээ мэдээлэл, судалгааг цаг

тухайд нь үнэн зөв гаргаж өгч, хүмүүнлэгийн тусламжийг хуваарилах ажлыг Улсын онцгой комиссын шуурхай штаб, олон улсын байгууллагатай хамтран зохион байгуулна.

### 9.2. Дотоодын хүмүүнлэгийн тусламжийг зохион байгуулах арга хэмжээ

| № | Хариу арга хэмжээ | Хэрэгжүүлэх арга зам | Хугацаа | Удирдан зохицуулах чиглэл хариуцсан байгууллага | Дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах байгууллага |
|---|---|---|---|---|---|
| 1 | Хүмүүнлэгийн багийн бүрэлдэхүүнийг байгуулах | Хүмүүнлэгийн багийн ажлын хэсгийг орон нутгийн Онцгой комиссын даргын тушаалаар батлах | Жил бүр | АОК, СОК | АЗДТГ, СЗДТГ, ОБГ |
| | | Гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээний ажлын хэсгийг орон нутгийн Онцгой комиссын даргын тушаалаар батлах | Жил бүр | АОК, СОК | АЗДТГ, СЗДТГ, ОБГ, |
| 2 | Хүмүүнлэгийн тусламж хүсэх, зогсоох | Гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээг гаргаж аймгийн засаг даргад танилцуулах | Тухай бүр | Ажлын хэсэг | АОК, СОК |
| 3 | | Гамшиг, аюулт үзэгдэл, ослын хор уршгийг арилгах, сэргээн босгох, тэмцэхэд орон нутгийн нөөц боломжоос давсан хохирол учирсан тохиолдолд хүмүүнлэгийн тусламж /хүнс, бараа материал, техник, багаж хэрэгсэл/ хүсэх шийдвэрийг улсын Онцгой комисс-д аймгийн Засаг дарга гаргах | Тухай бүр | АОК | АЗДТГ, СЗДТГ, ОБГ, Ажлын хэсэг |
| 6 | | Гамшгийн үеийн хохирол, хэрэгцээний үнэлгээг үндэслэн хүмүүнлэгийн тусламжийн үйл ажиллагааг зогсоох | Тухай бүр | АОК, СОК | СОК, ЗДТГ Ажлын хэсэг |
| 7 | Судалгаа хийх, мэдээллээр хангах | Тухайн үед үүссэн гамшгийн төрөл, нөхцөл байдалтай холбоотой мэдээ мэдээлэл, судалгааг мэргэжлийн байгууллагаас авч нэгтгэх | Тухай бүр | АОК | ГХА, МА, СОК, ШШ |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 8 | | Гамшгийн үед нэн шаардлагатай бусад бараа материал судалгааг гаргах, УОК-т хүргүүлэх | Тухай бүр | АОК | СОК, ГХА, ОБГ |
| | Хүмүүнлэгийн тусламжийг хүлээн авах, бүртгэх, хадгалах | Шаардлага хангасан, хүмүүнлэгийн тусламжийн бараа материал, техник хэрэгслийг хадгалах агуулахтай гэрээ байгуулах | Жил бүр | АЗДТГ | ААНБ |
| | | Хүмүүнлэгийн тусламжийн нэр төрөл, тоо хэмжээ, үнэ, чанар, сав баглаа боодол, үйлдвэрлэгчийн нэр болон хүчинтэй хугацаа зэргийг баримтжуулан бүртгэх | Тухай бүр | Ажлын хэсэг | АЗДТГ, СЗДТГ, ОБГ |
| 12 | | Мөнгөн хэлбэрээр үзүүлэх хүмүүнлэгийн тусламжийг Төрийн сан дахь нэмэлт дансанд хүлээн авч бүртгэх | Тухай бүр | АОК | СОК, СА |
| 14 | Хүмүүнлэгийн тусламжийг хуваарилан олгох | Гамшгийн үеийн хохирол, хэрэгцээний үнэлгээ болон холбогдох байгууллага, иргэнээс гаргасан саналыг үндэслэн хүмүүнлэгийн тусламжийг хуваарилан олгох саналыг гаргаж аймгийн Засаг даргаар баталгаажуулах | Тухай бүр | Хүмүүнлэгийн Баг | АОК, СОК, ТЗМА, |
| 15 | | Хүмүүнлэгийн тусламж олгох хуваарийг батлуулах | Тухай бүр | Хүмүүнлэгийн Баг | Хүмүүнлэгийн Баг |
| 16 | | Хүмүүнлэгийн тусламжийн бараа материалын хүчинтэй хугацааг харгалзан хуваарилсан газарт тээвэрлэн хүргэх, олгох ажлыг зохион байгуулах. | Тухай бүр | | АОК,СОК, ОБГ, ААНБ, ТЦБХСБ Тусламж үзүүлэгч талууд |
| 17 | | Хүмүүнлэгийн тусламж үзүүлэгч тал өөрөө хүссэн тохиолдолд холбогдох зардлыг хариуцан хүмүүнлэгийн тусламжийг хуваарилах, тээвэрлэн хүргэх, олгох ажлыг хамтран зохион байгуулах | Тухай бүр | Тусламж үзүүлэгч талууд | АОК, СОК, ОБГ |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 18 | | Хүмүүнлэгийн тусламжийн мөнгөн хөрөнгийн зарцуулалтыг аймгийн Онцгой комиссын хурлаар шийдвэрлэх | Тухай бүр | АОК | СОК, Санхүүгийн алба |
| 19 | | Аймгийн Онцгой комиссын хурлын шийдвэрийг үндэслэн хүмүүнлэгийн тусламжийн мөнгөн хөрөнгийн зарцуулалтын хуваарийг батлах | Тухай бүр | АОК | СОК, Санхүүгийн алба |
| 20 | | Хүмүүнлэгийн тусламжийг хүлээн авах, хадгалах, хуваарилах, тээвэрлэн хүргэх, олгох үйл ажиллагаатай холбогдон гарах зардлыг шийдвэрлэх | Тухай бүр | АОК, СОК | ГХА, ТЗМА, ОБГ |
| 21 | | Хүмүүнлэгийн туслах үзүүлэх цуваааны маршрутыг гаргаж аймгийн засаг даргаар батлуулах | Тухай бүр | ОБГ | АОК, СОК, |
| 22 | Хүмүүнлэгийн тусламжийн үйл ажиллагааг тайлагнах, хяналт тавих | Хүмүүнлэгийн тусламжийн мөнгөн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулахыг хориглох, хяналт тавих | Тухай бүр | Төрийн аудит | АОК, СОК |
| 23 | | Хүмүүнлэгийн тусламж хүлээн авсан, хуваарилсан талаарх мэдээллийн нэгдсэн сан байгуулах | Тухай бүр | ОБГ | АОК, СОК, |
| 24 | | Хүмүүнлэгийн тусламжийн талаарх тайлан, мэдээг нэгтгэн УОК-т хүргүүлэх | Тухай бүр | АОК | СОК, хүмүүнлэгийн баг, ОБГ |
| 25 | | Хүмүүнлэгийн тусламжийн талаарх тайлан, мэдээг өөрийн цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэх, холбогдох байгууллагын шилэн дансанд байршуулах | Тухай бүр | АОК, СОК | ОБГ |

## АРАВДУГААР БҮЛЭГ. ТӨСӨВ, САНХҮҮ

10.1. Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд шаардагдах зардлыг Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйл, Сангийн сайдын 2021 оны “Журам шинэчилэн батлах тухай” 61 дүгээр тушаал болон бусад холбогдох хууль, журмын хүрээнд шийдвэрлэнэ.

10.2. Хүч хэрэгсэл дайчлан ажилласан үйл ажиллагааны зардал, хуулийн этгээдийн техник тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, газар, барилга байгууламж, байрыг ашигласан зэрэг холбогдох зардлыг аймгийн онцгой комиссын шуурхай штаб нэгтгэн “Хүч хэрэгсэл дайчлан гаргах ажиллагаанд дайчлагдсан хуулийн этгээдэд нөхөн олговор олгох журам”-ын дагуу шийдвэрлүүлнэ.

## АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БУСАД

12.1.Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон үед хэрэгжүүлэн ажиллаж, холбогдох тайлан мэдээг тухай бүр УОК-ын ШШ, ОБЕГ-т газарт хүргүүлнэ.

12.2.Хэрэгжилтийг Онцгой байдлын газар хариуцан удирдан зохион байгуулна.

12.3. Төлөвлөгөөнд хэрэгжүүлэх ажлаа хэрэгжүүлээгүйгээс үүдэн хүний амь нас эд хөрөнгө хохирсон бол тухайн байгууллагын удирдлагад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлагыг тооцно.

---o0o---

Төсөл

Аймгийн Онцгой комиссын бүрэлдэхүүнийг
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 22.3, 24 дүгээр зүйлийн 2 дэх заалт, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.2 дахь заалт, ...................................................... тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Онцгой комиссын бүрэлдэхүүн, тэдгээрийн гүйцэтгэх чиг үүргийг нэгдүгээр, ажиллах журмыг хоёрдугаар, хурлын дэгийг гуравдугаар, сум хариуцуулсан хуваарийг дөрөвдүгээр, Шуурхай ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах, аврах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг Онцгой комиссын ажиллах журам болон холбогдох хууль тогтоомжтой нийцүүлэн шуурхай зохион байгуулж ажиллахыг Онцгой комиссын бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

3. Гамшгаас хамгаалах орон нутгийн алба, ерөнхий зориулалтын мэргэжлийн ангиудын томилгоог сумдын Засаг даргын захирамж, байгууллагын дарга /захирлын/ тушаалаар шинэчлэн, гүйцэтгэх үүргийг танилцуулж, бэлтгэл, бэлэн байдлыг хангуулж, үйл ажиллагааг нь зохицуулж ажиллахыг бүх сумдын Засаг дарга, албан байгууллага, аж ахуйн нэгжийн дарга нарт үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын ... оны “Аймгийн Онцгой комиссийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” А/... дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай

ЗАСАГ ДАРГА

Аймгийн Засаг даргын 2025 оны
.......дугаар сарын ..ны өдрийн .........дугаар
Захирамжийн нэгдүгээр хавсралт

## АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН, ЧИГ ҮҮРЭГ

| | Онцгой комиссын бүрэлдэхүүн | Албан тушаал | Чиг үүрэг |
|---|---|---|---|
| 1 | Дарга | Аймгийн Засаг дарга | Удирдлага зохион байгуулалтаар хангах, шаардлагатай арга хэмжээ, хөрөнгийг шийдвэрлэх, төлөвлөх |
| 2 | Орлогч дарга | Онцгой байдлын газрын дарга | |
| 3 | Гишүүн | Аймгийн Засаг даргын орлогч | |
| 4 | Гишүүн | Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга | Нэрвэгдэгсдэд болон гамшиг ослын голомтод ажиллаж байгаа мэргэжлийн анги, сайн дурынхныг томилох, ус хоол хүнсээр хангах, үүрэг гүйцэтгэж байгаа автомашин техник хэрэгслийг шатах тослох материалаар хангах |
| 5 | Гишүүн | Арвайхээр сумын Засаг дарга | |
| 6 | Гишүүн | Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга | Гамшгийн хохирол хэрэгцээний үнэлгээг үндэслэн олон улсын хүмүүнлэгийн тусламжийг хүлээн авах, бүртгэх байршуулах хадгалах тээвэрлэх хувиарлах үйл ажиллагааг зохион байгуулах, нэрвэгдэгсдэд холбогдох дүрэм журмын дагуу дотоодын нөөцөөс хэрэгцээт бараа, бүтээгдэхүүнийг хувиарлах хангалтыг зохион байгуулах, шаардлагатай хөрөнгийг зарцуулах |
| 7 | Гишүүн | Хууль, эрх зүйн хэлтсийн дарга | Холбогдох захирамж, тушаал, шийдвэрийг хуулийн дагуу шуурхай гаргах хэрэгжилтийг хангуулах |
| 8 | Гишүүн | Цэргийн штабын дарга | Нүүлгэн шилжүүлэх, хүн хүч хэрэгслийн тооцоог гаргах, дайчилгаа зохион байгуулах |
| 9 | Гишүүн | Зэвсэгт хүчний дугаар ангийн захирагч | Аврах ажиллагаа зохион байгуулахад учирч буй саадыг арилгах зорилгоор тэсэлгээний ажлыг зохих журмын дагуу аюулгүй байдлыг хангаж гүйцэтгэх, хүн хүч техник хэрэгслийн дэмжлэг үзүүлэх, гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэх |
| 10 | Гишүүн | Цагдаагийн газрын дарга | Нийгмийн хэв журам сахиулах, эрэн хайх аврах ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэх, нэрвэгдэгсдийг нүүлгэн шилжүүлэх үеийн аюулгүй байдлыг хангах, нийтийг хамарсан эмх замбараагүй байдлаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох улсын онц чухал объектын харуул хамгаалалтыг зохион байгуулах |

<table>
<tr><td>11</td><td>Гишүүн</td><td>Тагнуулын ерөнхий газрын харьяа Дундговь аймаг дахь хэлтсийн дарга</td><td>Терроризмтой тэмцэх, урьдчилан сэргийлэх цацраг идэвхт болон химийн хорт бодис тэсэрч дэлбэрэх бодисын эргэлтэд хяналт тавих ухуулга сурталчилгаа хийх</td></tr>
<tr><td>12</td><td>Гишүүн</td><td>Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга</td><td>Гамшиг, ослын үед хүн амыг түр байрлуулах, хорогдох байрыг холбогдох норм, стандартын дагуу барьж байгуулах, төхөөрөмжлөх, нөөц бүрдүүлэх, гамшиг ослын голомтоос нүүлгэн шилжүүлэх, түр байр дэлгэж иргэдийн амьдрах нэн түрүүний хэрэгцээг тодорхойлох, хангалтыг зохион байгуулах</td></tr>
<tr><td>13</td><td>Гишүүн</td><td>Эрүүл мэндийн газрын дарга</td><td rowspan="2">Гамшгийн голомтод нэрвэгдэгсдийг эрэмбэлэн ангилж, эмнэлгийн яаралтай тусламж үйлчилгээ үзүүлэх, эмнэлэгт тээвэрлэн хүргэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах, хээрийн нөхцөлд нэрвэгдэгсдэд эмнэлгийн шаардлагатай бүхий төрлийн тусламж үйлчилгээ үзүүлэх, эмнэл зүйн лабораторийн шинжилгээ хийх, өвчний тархалтыг хязгаарлах, халдвар эсэргүүцэх арга хэмжээг шуурхай зохион байгуулах, гамшиг ослын үед хээрийн эмнэлэг болон яаралтай тусламжийн хэсгийг эм эмнэлэгийн хэрэгслээр хангах, нөөц бүрдүүлэх, хээрийн нөхцөлд хөдөлгөөнт эмийн сан ажиллуулах</td></tr>
<tr><td>14</td><td>Гишүүн</td><td>Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн захирал</td></tr>
<tr><td>15</td><td>Гишүүн</td><td>Зооноз өвчин судлалын төвийн дарга</td><td>Зоонозын өвчнөөс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, эрсдэлийг үнэлэх, голомтыг цомтгож хор уршгийг арилгах зорилгоор эмчлэн тусгаарлах, хавьтлыг тогтоож хяналтад авах, ариутгал халдваргүйтгэл хийх зэрэг хариу арга хэмжээг авах</td></tr>
<tr><td>16</td><td>Гишүүн</td><td>Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга</td><td>Химийн хоргүй байгаль орчинд сөрөг нөлөөгүй арга технологиор бэлчээрийн болон тариалангийн талбайд хөнөөл учруулдаг хортон шавьж, мэрэгчдийн тархалттай тэмцэх, үрийн агуулах, техник тоног төхөөрөмжийн бэлтгэл бэлэн байдал стандартын шаардлагыг хангуулах, Зудын эрсдэлийг бууруулах.</td></tr>
<tr><td>17</td><td>Гишүүн</td><td>Мал эмнэлгийн газрын дарга</td><td>Мал амьтны халдварт, гоц халдварт өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, вакцинжуулах, халдварын голомтод мал амьтанд үзлэг тандалт хийж оношийг тогтоох, тусгаарлах, хязгаарлалт хорио цээрийг дэглэм тогтоох, ариутгал халдваргүйтгэлийн арга хэмжээг холбогдох дүрэм журамд заавар стандартын дагуу авч хэрэгжүүлэх</td></tr>
</table>

| | | | |
|---|---|---|---|
| 18 | Гишүүн | Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга | Мал, амьтан ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх |
| 19 | Гишүүн | УЦУОШТөвийн дарга | Цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээг ард иргэдэд түргэн шуурхай хүргэх, усыг бохирдох хамгаалах |
| 20 | Гишүүн | МУЗН-ийн салбарын дарга | Гамшиг, ослын үед нэрвэгдэгсдэд анхны тусламж сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, сайн дурын хэсгийг томилж ажиллуулах |
| 21 | Гишүүн | ЭБЦТС, ТӨХК-ний аймаг дахь салбарын дарга | Гамшиг ослын үед цахилгаан эрчим хүчээр хангах, цахилгаан станц шугамд гарсан эвдрэл, гэмтлийг засварлах, хойшлуулшгүй сэргээн босгох ажлыг яаралтай зохион байгуулах |
| 22 | Гишүүн | Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга | Гамшиг, ослын үед нэрвэгдэгсдэд болон аврах ажиллагаанд дэмжлэг үзүүлж байгаа иргэдийн хэрэгцээг тодорхойлж, орон байр дулаан хувцас, хөнжил, гудас зэргээр хангах |
| 23 | Гишүүн | ТБОНӨОГазрын захирал | Цэвэр бохир усны шугам сүлжээнд гарсан эвдрэл, гэмтлийг засварлах, сэргээн босгох ажил гүйцэтгэх, дулааны эрчим хүчны системийн аюулгүй ажиллагааг хангах, шугам сүлжээнд гарсан эвдрэл гэмтлийг илрүүлэх, засвар үйлчилгээ хийх, хойшлуулшгүй сэргээн босгох ажлыг гүйцэтгэх |
| 24 | Гишүүн | Авто тээврийн төвийн дарга | Нэрвэгчдэд тусламжийн бараа, материал тээвэрлэн хүргэх, гамшиг ослын голомтоос хүн ам, эд хөрөнгө, түүх дурсгалын үнэт зүйлсийг нүүлгэн шилжүүлэх, бусад шаардлагатай тээврийн үйлчилгээ үзүүлэх |
| 25 | Гишүүн | ТӨХК-ний гүйцэтгэх захирал | Гамшиг ослын улмаас нурсан, эвдэрсэн зам гүүрт засвар хийх, гарц гаргах, түр гүүр тавих, хойшлуулшгүй сэргээн босгох ажлыг гүйцэтгэх, (цасны нурам, мөсний хахаа зайлуулах, нурангинд дарагдсан зам орц, гарцыг чөлөөлөх гэх мэт) |
| 26 | Нарийн бичгийн дарга | Онцгой байдлын газрын орлогч, УСТасгийн дарга, | Хуралдаан зохион байгуулах, бэлтгэл ажлыг хангах, хуралдааны тэмдэглэл бичиг баримтыг хөтлөх, гарсан шийдвэрийг нэн даруй холбогдох газарт хүргүүлэх, шийдвэрлэлтэд хяналт тавьж хэрэгжилтийг хангуулах |
| 27 | Орон нутгийн онцлогоос хамааран нэмэлт, өөрчлөлтийг хийх | | |

- оОо-

Аймгийн Засаг даргын 2026..... оны
..... дугаар сарын .......ны өдрийн ........ дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

# АЙМАГ БОЛОН СУМДЫН ОНЦГОЙ КОМИССЫН АЖИЛЛАХ ЖУРАМ

## Нэг. Нийтлэг үндэслэл

Аймгийн Засаг дарга нутаг дэвсгэрийн хэмжээнд гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, бүс нутгийн хүчээр хэрэгжүүлэх бололцоогүй болж тусламж, дэмжлэг үзүүлэх талаар албан ёсны хүсэлт тавьсан буюу өөрийн санаачилгаар хүн хүч техник хэрэгсэл, материаллаг нөөцийг зохих хууль тогтоомжийн дагуу дайчлан гаргах, үүссэн цагийн байдалтай холбогдуулан хэрэгжүүлж байгаа арга хэмжээг уялдуулан зохицуулах, хэрэгжилтийг хангуулах хяналт тавихад энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.1. Аймгийн Онцгой комисс нь Гамшгаас хамгаалах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэ журмыг удирдлага болгон үйл ажиллагаагаа явуулна.

1.2. Комиссын бүрэлдэхүүнийг аймгийн Засаг дарга батална.

1.3. Комиссыг тухайн аймгийн Засаг дарга тэргүүлэх бөгөөд орлогч дарга нь аймгийн Онцгой байдлын газрын дарга, суманд тухайн хариуцсан албан тушаалтан байна.

1.4. Комиссын гишүүд нь ажлын үнэмлэхтэй байна.

1.5. Комиссын хурал нийт гишүүдийн 51-иас доошгүй хувийн ирцтэй бол хүчин төгөлдөр болох бөгөөд хэлэлцсэн асуудлыг хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэж, тэмдэглэл гаргана.

1.6. Комиссын дарга нь холбогдох хууль тогтоомжоор олгогдсон үүрэг, зорилтоо хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар албан даалгавар, тогтоол, хурлын тэмдэглэл, албан бичиг гаргана.

1.7. Комиссоос гаргасан шийдвэрийг орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэд өмчийн төрөл, хэлбэр үл харгалзан дагаж мөрдөнө.

1.8. Комиссын өдөр тутмын үйл ажиллагааг аймгийн онцгой комиссын нарийн бичгийн дарга эрхэлнэ.

1.9. Комисс нь албан ёсны тамга тэмдэг, хэвлэмэл хуудастай байна.

## Хоёр. Комиссын эрх, үүрэг

2.1. Комиссын гишүүд дараах үүрэгтэй байна

2.1.1. Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний бэлтгэлийг хангуулах ажлыг орон нутгийн төрийн захиргааны болон аж ахуйн нэгж, төрийн бус, олон нийтийн байгууллагаар гүйцэтгүүлэх Монгол улсын Шадар сайд, Улсын онцгой комиссоос энэ чиглэлээр тусгайлан өгсөн үүргийг хэрэгжүүлэх.

2.1.2. Гамшгийн голомтод аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг удирдан зохион байгуулах эдгээр арга хэмжээнд оролцож байгаа байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах.

2.1.3. Гамшгийн үед цагийн байдалд мэргэжлийн байгууллагаас өгсөн үнэлэлт, дүгнэлт авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг хэлэлцэж, шийдвэр гаргах.

2.1.4. Гамшгийн голомтод Засгийн газар, олон улсын хүмүүнлэгийн байгууллагаас олгосон бараа материал, тусламжийг хүргэх болон тээвэрлэх явцад хяналт тавих.

2.1.5. Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, нэрвэгдэгсдэд шуурхай тусламж үзүүлэх, нүүлгэн шилжүүлэх ажилд шаардагдах хүн хүч, техник хэрэгслийг зохих журмын дагуу дайчлан гаргах асуудлыг орон нутгийн төрийн захиргааны болон бусад байгууллага, албан тушаалтантай хамтран шийдвэрлэж, зохицуулах шаардлагатай нэмэгдэл хүч, техник хэрэгслийг дайчлан гаргах.

2.1.6. Гамшгийн аюулаас хүн ам, мал амьтан, хүрээлэн байгаа орчныг аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэхэд тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хүч хүрэлцэхгүй болсон үед дээд шатны онцгой комисст албан ёсны хүсэлт тавих.

2.1.7. Комиссоос олон нийтэд хүргэх анхааруулга, санамж болон авч хэрэгжүүлж буй арга хэмжээнийхээ талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр шуурхай мэдээлж байх.

2.1.8. Гамшиг тохиолдсон үед хохирол, хэрэгцээг тодорхойлох, үнэлэх ажлын хэсгийг зохих мэргэжлийн алба хаагчдын бүрэлдэхүүнтэйгээр томилон ажиллуулж дүгнэлт гаргах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулах

2.2.Комисс дараах эрхтэй байна.

2.2.1. Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэх асуудлаар орон нутгийн төрийн захиргааны болон аж ахуйн нэгж, байгууллагын дарга нарт үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах, гүйцэтгэлд нь хяналт тавих.

2.2.2. Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээнд орон нутгийн төрийн захиргааны болон мэргэжлийн байгууллага, албан тушаалтан, гадаадын хөрөнгө оруулалттай болон дотоодын аж ахуйн нэгж, иргэдийг хууль тогтоомжийн дагуу өмчийн төрөл, хэлбэр үл харгалзан татан оролцуулах.

2.2.3. Холбогдох байгууллага, албан тушаалтнаас шаардлагатай тайлан, мэдээ мэдээлэлд судалгаа гаргуулан авах, илтгэл мэдээллийг хурлаараа хэлэлцэж шийдвэр гарган биелүүлэхийг шаардах, хяналт тавих.

2.2.4. Гамшгийн голомтод хэрэгжүүлж байгаа арга хэмжээг шалгаж, дүгнэлт гаргах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авах.

2.2.5. Комиссоос болон нийтэд хүргэх анхааруулга, санамж болон авч хэрэгжүүлж буй арга хэмжээнийхээ талаар мэдээлэл хийхдээ хэвлэл мэдээллийн хэрэгслийг холбогдох журмын дагуу ашиглах.

## Гурав. Комиссын зардал

3.1. Комисс нь нутаг дэвсгэртээ гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдсон хөрөнгө, зардлыг тухайн жилийн төсөвтөө тусган зохих журмын дагуу захиран зарцуулна.

3.2. Комиссын тухайн үеийн үйл ажиллагааны зардлыг мэргэжлийн байгууллага, гамшгийн хохирол хэрэгцээний үнэлгээний ажлын хэсэг бусад алба, мэргэжлийн ангийн гаргасан тооцоо судалгаа саналыг үндэслэн Засаг даргын нөөц хөрөнгө, Гамшгаас хамгаалах эрсдэлийг бууруулах зардал болон бусад эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

3.3. Аймаг, сумын онцгой комисс нь гамшгийн улмаас учирсан хохирлыг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгоход шаардагдах нэмэлт санхүүжилттэй холбоотой асуудал тавихдаа тухайн онд батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгө, Гамшгаас хамгаалах Гамшгийн эрсдэлийг бууруулах зардлын зарцуулалтын тайлан, санхүүгийн анхан шатны материалыг Улсын онцгой комисст хүргүүлнэ.

## Дөрөв. Сумын Онцгой комисст чиг үүрэг хариуцуулах

4.1. Аймгийн Онцгой комиссын ажиллах журмыг үндэслэн сумын Онцгой комиссын ажиллах журмыг сумын Засаг дарга батална.

4.2. Сумын Онцгой комиссын дарга нь Засаг дарга, орлогч дарга нь ЗДТГ-ын дарга байна.

4.3. Сумын Онцгой комисс нь нутаг дэвсгэртээ гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжүүлэх аймгийн Онцгой комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангах үүрэгтэй ажиллана.

4.4. Сумын Онцгой комисс нь гамшгийн үед зохион байгуулсан арга хэмжээ, үр дүнг гамшгийн нөхцөл байдал дууссан тухай бүр, авч хэрэгжүүлсэн арга хэмжээнийхээ тайланг жил бүрийн 11 дүгээр сард багтаан аймгийн Онцгой комисст танилцуулна.

4.5. Сумын Онцгой комисс нь нутаг дэвсгэртээ гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдсон хөрөнгө, зардлыг жилийн төсөвтөө тусган зохих журмын дагуу захиран зарцуулж, зарцуулалтын тайланг хагас, бүтэн жилээр аймгийн Онцгой байдлын газар (онцгой комисс)-т ирүүлж байна.

## Тав. Бусад зүйл

5.1. Сумын Онцгой комисс нь гамшгийн үед зохион байгуулсан арга хэмжээ, үр дүнг гамшгийн нөхцөл байдал дууссаны дараа тухай бүр аймгийн Онцгой комисст, аймгийн Онцгой комисс нь хэрэгжүүлсэн арга хэмжээнийхээ тайланг жил бүрийн 12 дугаар сард Улсын Онцгой комисст ирүүлнэ.

5.2. Комисс нь дүрэмдээ орон нутгийн онцлогийг тусгасан заалт нэмж оруулж болно.

5.3. Өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй байгууллага, аж ахуй нэгж, албан тушаалтан, иргэдэд захиргааны шийтгэл ногдуулах саналаа эрх бүхий холбогдох байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлнэ.

- оОо-

## Товчилсон үгийн тайлбар

АОК- Аймгийн Онцгой комисс
АУГ-Ажиллагааны удирдлагын газар
АЗД-Аймгийн Засаг дарга
ААНБ- Аж ахуй нэгж байгууллага
АДОБАЗ- Аймаг дундын отрын бэлчээрийн ашиглалтын захиргаа
ББ-Боловсролын байгууллага
ББХАҮМА- Байгалийн болон химийн аюулыг үнэлж мэдээлэх алба
БХБА-Барилга хот байгуулалтын алба
БОА-Байгаль орчны алба
БОАЖЯ-Байгаль орчин аялал жуулчлалын яам
БОУУА-Байгаль орчины алба
БШУЯ-Боловсрол шинжлэх ухааны яам
ГТТГ-Гал түймэртэй тэмцэх газар
ГХА- Гамшгаас хамгаалах алба
ГХБАСЗ- Газар хөдлөлтийн байнгын ажиллагаатай салбар зөвлөл
ГХБХБГ-Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ГХОНА- Гамшгаас хамгаалах орон нутгийн алба
ГХЯ-Гадаад харилцааны яам
ГЭБОНЗ- Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөл
ДОК-Дүүргийн онцгой комисс
ДЦ-Дотоодын цэрэг
ДЦС-Дулааны цахилгаан станц
ЗГ-Засгийн газар
ЗДТГ- Засаг даргын тамгын газар
ЗТА-Зам тээврийн алба
ЗХЖШ-Зэвсэгт хүчний жанжин штаб
ИТХ- Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МБЦХА- Мэргэжлийн болон цацрагийн хяналтын алба
МА-Мэргэжлийн анги
МУЗН-Монголын улаан загалмайн нийгэмлэг
МХХА-Мэдээлэл харилцаа холбооны алба
МЭА-Мал эмнэлгийн алба
МЭГ-Мал эмнэлгийн газар
НЗБ-Нутгийн захиргааны байгууллага
НХМА-Нийгэм хамгааллын мэргэжлийн алба
ОБГ- Онцгой байдлын газар
ОБЕГ-Онцгой байдлын ерөнхий газар
ОНӨААТҮГ- Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
СОК-Сумын онцгой комисс
СӨББ-Сургуулийн өмнөх боловсролын байгууллага
СШШ-Сумын шуурхай штаб
ТЗМА-Тусгай зориулалттай мэргэжлийн анги
ТЦБ-Төрийн цэргийн байгууллага
ТЦБХСБ- Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллага
ТЭХА-Түлш, эрчим хүчний алба
ТӨХ-Төрийн өмчит хувьцаат компани
УЗХ-Улаан загалмайн хороо
УОК-Улсын онцгой комисс
УУА-Уул уурхайн алба
УЦУОШТ- Ус цаг уур орчны шинжилгээний төв
ХЖСА-Хэв журам сахиулах алба
ХЗДХЯ-Хууль зүй дотоод хэргийн яам
ХНХА-Хөдөлмөр нийгмийн хамгааллын алба
ХНХЯ-Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам

ХХААА- Хүнс хөдөө аж ахуйн алба
ХХААХҮЯ-Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам
ХХЕГ-Хил хамгаалах ерөнхий газар
ХЦА-Хилийн цэргийн анги
ЦАҮМА-Цацраг аюулыг үнэлж мэдээлэх алба
ЦГ-Цагдаагийн газар
ЦХМА-Цацраг химийг мэдээлэх алба
ШШ-Шуурхай штаб
ЭМА-Эрүүл мэндийн алба
ЭМГ-Эрүүл мэндийн газар
ЭМТҮМА-Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний мэргэжлийн анги
ЭМЯ-Эрүүл мэндийн яам
ЭХА-Эрчим хүчний алба
ЭХЯ-Эрчим хүчний яам

**Загвар төлөвлөгөө**

ДУНДГОВЬ АЙМГИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАВСРАЛТ

**МАНДАЛГОВЬ ХОТ**

ХАВСРАЛТ 1

## ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН:

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн түвшинд хийсэн гамшгийн эрсдэлийн тойм судалгаа, эрсдэлийн үнэлгээний дүн, болон бусад түвшинд хийсэн гамшгийн эрсдэлийн үнэлгээний дүнг аймгийн хэмжээгээр, сум тус бүрээр, гамшгийн төрөл тус бүрээр дэлгэрэнгүй оруулна.

Жишээ нь: 2019 онд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн түвшинд хийсэн гамшгийн эрсдэлийн тойм судалгаагаар гамшгийн эрсдэлийн түвшин Өмнөговь аймаг 39 оноотойгоор ДУНД гэж тодорхойлогдсон.

**Өмнөговь аймгийн гамшгийн эрсдэлийн тойм судалгааны үр дүн**

| | Аюул | Өртөх | Эмзэг | Чадавх | Эрсдэл |
|---|---|---|---|---|---|
| Авто осол | 58 | 52 | 43 | 49 | 34 |
| Обьектын түймэр | 53 | 55 | 47 | 50 | 35 |
| Хүчтэй салхи | 69 | 62 | 57 | 52 | 45 |
| Мал, амьтны гоц халдварт өвчин | 66 | 59 | 49 | 53 | 40 |
| Зуд | 72 | 55 | 53 | 51 | 43 |
| Ган | 73 | 54 | 51 | 54 | 41 |
| Үер | 62 | 54 | 55 | 54 | 38 |
| Хүний гоц халдварт, халдварт өвчин | 67 | 51 | 46 | 51 | 38 |
| Газар хөдлөлт | 65 | 67 | 60 | 48 | 48 |
| Осол | 49 | 47 | 47 | 44 | 32 |
| Нийт дүн | **63** | **56** | **51** | **51** | **39** |

**Гамшгийн эрсдэлийн түвшин тодорхойлох хүснэгт**

| түвшин | Индекс/оноо | Өнгөний илэрхийлэл |
|---|---|---|
| Бага | 0-30 | |
| Дунд | 31-60 | |
| Их | 61-100 | |

**Эрсдэлийн их түвшинг хүлцэж үл болох эрсдэл:**

Хүлцэж үл болох түвшинд байгаа эрсдэлийн хувьд өртөг ихтэй байсан ч эрсдэлийг бууруулах арга хэмжээг яаралтай авах шаардлагатай

**Эрсдэлийн дунд түвшинг хүлцэх эрсдэл:**

Хүлцэх түвшинд байгаа эрсдэлийн хувьд эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөж, өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүйгээр хэрэгжүүлэх шаардлагатай

**Эрсдэлийн бага түвшинг хүлээж авах эрсдэл:**

Хүлээж авах түвшинд байгаа эрсдэлийн хувьд ямар нэг арга хэмжээ авах шаардлагагүй ба тухайн байдалд хяналт тавих, ажиглах шаардлагатай

**ХАВСРАЛТ 2**

## ДУНДГОВЬ АЙМГИЙН ТАНИЛЦУУЛГА

### ХҮН АМ ЗҮЙ

- Хүн ам: 65645. (Үүнээс 50,3% эрэгтэйчүүд, 49,7% эмэгтэйчүүд)
- Өрхийн тоо: 21278. (Үүнээс малчин өрх 5819).
- Хүн амын 39 хувь Мандалговь хотод, 21,4 хувь нь ...... сумдын төвд, ... хувь нь хөдөөд суурьшиж байна.
- Хөдөлмөр эрхлэх насаар нь ангилвал 32,1 хувийг 0-15 насны хүүхэд, 62 хувийг 16-59 насны, 5,9 хувийг 60-аас дээш насны хүн ам эзэлдэг.
- Хөгжлийн бэрхээлтэй иргэд: 1985 (Үүнээс ... хувь нь эрэгтэй, ... хувь нь эмэгтэй)

Дундговь аймгийн хүн амын тоо /20.... он/

<table>
<tr><th rowspan="3">Сумын нэр</th><th rowspan="3">Нийт хүн ам</th><th rowspan="3">Өрх</th><th colspan="11">Үүнээс</th></tr>
<tr><th rowspan="2">Эр</th><th rowspan="2">Эм</th><th colspan="3">Суурин газарт</th><th colspan="3">Хөдөөд</th><th colspan="3">Хөгжлийн бэрхшээлтэй</th></tr>
<tr><th>Бүгд</th><th>Эр</th><th>Эм</th><th>Бүгд</th><th>Эр</th><th>Эм</th><th>Бүгд</th><th>Эр</th><th>Эм</th></tr>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td>Нийт</td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr>
</table>

## ДЭД БҮТЦИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Зам, гүүр, төмөр зам, нисэх буудал, ШТС, далан, хаалт, барилга байгууламж, усны нөөц, инженерийн шугам сүлжээ, эрчим хүч, харилцаа холбоо

| Сумдын нэр | Тоо, байрлал | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Цахилгаан станц /тоо/ | Цахилгааны нэгдсэн сүлжээ | Нисэх онгоцны буудал /тоо/ | Төмөр замын буудал /тоо/ | Засмал зам Холбогдсон Сум /тоо/ | Инженерийн шугам сүлжээ /км/ | Улсын онц чухал обьект /тоо/ | ШТС /тоо/ |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| **Нийт** | | | | | | | | |

## ХӨДӨӨ АЖ АХУЙ

20... оны эцэст 5819 малчин өрх байгаа нь өнгөрсөн оноос 172 өрхөөр өссөн байна. Аймгийн хэмжээнд 501 мянгат малчинтай болсон байна. Хамгийн олон малтай сумаар Сайнцагаан 289869, Гурвансайхан 242353, Баянжаргалан сум 205078, хулд 194503, Луус 190396 толгой мал тус тус тоолуулсан байна. Малын таван төрлөөр нь авч үзвэл тэмээгээр Цагаандэлгэр сум 27932, адуугаар Дэрэн сум 11895, үхрээр Өлзийт сум 5313, хониор ....... сум 67161, ямаагаар .........сум 227212 толгойгоор тус тус тэргүүлж байна. ....... сум нь тэмээн сүргээрээ аймагтаа болон улсад тэргүүлж байна.

Мөн мал тооллогын дүнгээр аймгийн хэмжээнд 890 толгой сарлаг, 5 хайнаг, 163 толгой гахай, 257 шувуу үүнээс 242 тахиа, 11 галуу, 4 цацагт хяруул тус тус тоолуулсан байна.

Газар тариалангийн салбарт нийт 180.5 га талбайд тариалалт хийсний 64.2 га талбайд төмс, 79.5 га талбайд хүнсний ногоо, 36.7 га талбайд тэжээлийн ургамал тариалснаас 544.3 тн төмс, 719.7 тн хүнсний ногоо, 276.3 тн тэжээлийн ургамал хураажээ. Аймгийн хэмжээнд нийт 5626.6 тн өвс, 1009.9 тн гар тэжээл бэлтгэн нөөцөлсөн байна.

**20.... оны жилийн эцсийн малын тоо**

| № | Сумдын нэр | Бүгд | Тэмээ | Адуу | Үхэр | Хонь | Ямаа |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | | | | | | | |
| 2 | | | | | | | |
| 3 | | | | | | | |
| 4 | | | | | | | |
| 6 | Бүгд | ........... | ......... | .......... | .......... | ............ | ............. |

**УУЛ УУРХАЙ**

Дундговь аймаг ашигт малтмалын 80 гаруй орд, 200 гаруй илрэлтэйгээс .................... стратегийн ач холбогдолтой томоохон орд газарт тогтоогдож нийт нутаг дэвсгэрийн .......................... зэрэг 14 компаниуд ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагаа явуулж байна.

| № | Сумдын нэр | Уурхайн тоо | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Алт | Зэс | Төмөр | Нүүрс | Жонш | ??? | ??? | ??? |
| 1 | | | | | | | | | |
| 2 | | | | | | | | | |
| 3 | | | | | | | | | |
| 4 | | | | | | | | | |

**ХАВСРАЛТ 2**

## ГАМШГААС ХАМГААЛАХ АЛБА, МЭРГЭЖЛИЙН АНГИУДЫН ХҮЧ ХЭРЭГСЛИЙН СУДАЛГАА

**Гамшаас хамгаалах албаны хүч хэрэгслийн судалгаа**

| д/д | Гамшгаас хамгаалах албаны нэр | ГХА-ны бүрэлдэхүүн | Мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн | Тээврийн хэрэгсэл | | | | | Механизм | | | | ............ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Суудлын | Ачааны | Хүн тээвэр | Автоцестерн | ........... | Ковш | эксиватор | автогейдр | ............ | ..................... |
| 1 | Эрүүл мэндийн алба | 120 | 100 | 9 | 0 | 6 | | | | | | | |
| 2 | Хэв журам сахиулах алба | | | | | | | | | | | | |
| 3 | ХХАА алба | | | | | | | | | | | | |
| Нийт | | | | | | | | | | | | | |

**Гамшаас хамгаалах албаны багаж, техник хэрэгслийн судалгаа**

| д/д | Гамшгаас хамгаалах албаны нэр | ХЗМ-ийн хэрэгсэл | | | | Мотопомп | Цахилгаан үүсгүүр | Гэр | Палатак | Вагончик | ......... |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Иридиум | Богино долгионы радио станц | Хэт богино долгионы радио станц | Сүлжээ үүсгэгч төхөөрөмж /старлинк/ | | | | | | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Эрүүл мэндийн алба | - | - | 5 | | 1 | 1 | 3 | 3 | | |
| 2 | Хэв журам сахиулах алба | | | | | | | | | | |
| 3 | ХХАА алба | | | | | | | | | | |
| 4 | Түлш, эрчим хүчний алба | | | | | | | | | | |
| | ................... | | | | | | | | | | |
| Нийт | | | | | | | | | | | |

**Сумдын хүч хэрэгслийн судалгаа**

| д/д | Сумын нэр | Онцгой комиссын гишүүд | Мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн | Тээврийн хэрэгсэл | | | | | Механизм | | | | ............ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Суудлын | Ачааны | Хүн тээвэр | Автоцестерн | ........... | Ковш | экскиватор | автогейдр | ............ | .................... |
| 1 | Баян-Овоо | | | | | | | | | | | | |
| 2 | ........................ | | | | | | | | | | | | |
| 3 | | | | | | | | | | | | | |
| 4 | | | | | | | | | | | | | |
| Нийт | | | | | | | | | | | | | |

**Сумдын багаж, техник хэрэгслийн судалгаа**

| д/д | | ХЗМ-ийн хэрэгсэл | Мотопомп | Цахилгаан үүсгүүр | Гэр | Палатак | Вагончик | ......... |
|---|---|---|---|---|---|---|---|---|

| | Гамшгаас хамгаалах албаны нэр | Иридиум | Богино долгионы радио станц | Хэт богино долгионы радио станц | Сүлжээ үүсгэгч төхөөрөмж /старлинк/ | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Баян-Овоо | - | - | 5 | | 1 | 1 | 3 | 3 | | |
| 2 | ........................ | | | | | | | | | | |
| 3 | | | | | | | | | | | |
| 4 | | | | | | | | | | | |
| Нийт | | | | | | | | | | | |

**ХАВСРАЛТ 3**

## ДАЙЧЛАН ГАРГАХ ХҮЧ ХЭРЭГСЛИЙН СУДАЛГАА

**Дайчлан гаргах хүний тоо**

| № | Сумдын нэр | Дайчлагдан ажиллах зориулалт | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Эрэн хайх аврах ажиллагаа, нүүлгэн шилжүүлэх ажиллагаанд оролцох | Эрүүл мэндийн тусламж үзүүлэх | | Цахилгаанчин | Инженерийн шугам сүлжээ засварлах | Цахим сүлжээ, программ хангамж дээр ажиллах | .......... |
| | | | эмч | сувилагч | | | | |
| 1 | Баян-Овоо | | | | | | | |
| 2 | ........................ | | | | | | | |
| Нийт | | | | | | | | |

**Дайчлан гаргах техник хүч хэрэгслийн судалгаа**

| д/д | Сумын нэр | Тээврийн хэрэгсэл | | | | | Механизм | | | | ............ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Суудлын | Ачааны | Хүн тээвэр | Автоцестерн | ........... | Ковш | экскиватор | автогейдр | ............. | ................... |
| 1 | Баян-Овоо | | | | | | | | | | |
| 2 | ...................... | | | | | | | | | | |
| 3 | | | | | | | | | | | |
| 4 | | | | | | | | | | | |
| Нийт | | | | | | | | | | | |

**Дайчлагдан ажиллуулах багаж, техник хэрэгслийн судалгаа**

| д/д | Гамшгаас хамгаалах албаны нэр | ХЗМ-ийн хэрэгсэл | | | | Мотопомп | Цахилгаан үүсгүүр | Гэр | Палатак | Вагончик | ......... |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Иридиум | Богино долгионы радио станц | Хэт богино долгионы радио станц | Сүлжээ үүсгэгч төхөөрөмж /старлинк/ | | | | | | |
| 1 | Баян-Овоо | - | - | 5 | | 1 | 1 | 3 | 3 | | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | ........................ | | | | | | | | | | |
| 3 | | | | | | | | | | | |
| 4 | | | | | | | | | | | |
| Нийт | | | | | | | | | | | |

**ХАВСРАЛТ 4**

## НИСДЭГ ТЭРЭГ БУУХ, ХӨӨРӨХ ТАЛБАЙН БАЙРЛАЛ

| № | Сумдын нэр | Нисдэг тэрэг буух, хөөрөх талбайн байрлал | Байр зүйн солбилцол | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Баян-Овоо | Сумын төвөөс баруун зүгт 8 км-т “.........” газар | 43,36,161 104,25,833 | ........................ |
| 2 | ........................ | Сумын төвөөс урд зүгт 5 км-т “.........” газар | 43,28,082 103,30,667 | ........................ |
| 3 | ........................ | xxx | 43,00,575 106,05,176 | ........................ |
| 4 | ........................ | ........................ | ........................ | |

**ХАВСРАЛТ 5**

## Аймгийн цэвэр усаар хангах нөөцийн судалгаа

| № | Худгийн нэр | xd | xm | xs | yd | ym | ys | H | Зориулалт | Худгийн гүн | Ундарга л/с | Гаргасан огноо | Эзэмшигч | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | | 49 | 7 | 52 | 104 | 41 | 15 | - | 0,4 | 25 | 2 | 2006 | А.Галт | Ундарга муу |

**ХАВСРАЛТ 6**

## АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ЗАХИРАМЖИЙН ТӨСЛҮҮД ОРНО

**ХАВСРАЛТ 7**

### Аймгийн Онцгой комиссын утасны дугаар, гэрийн хаягийн судалгаа

| № | Томилгоот албан тушаал | Овог, нэр | Албан тушаал | Гэрийн хаяг | Утасны дугаар |
|---|---|---|---|---|---|
| 1 | Онцгой комиссын дарга | Б.Дорж | Засаг дарга | ......сумын ....р багийн А-33-46 тоот | 9911..... |
| 2 | Комиссын орлогч дарга | ................ | .................. | ...................... | .................... |
| 3 | Комиссын нарийн бичгийн дарга | ................ | .................. | ...................... | .................... |
| 4 | | | | | |

**ХАВСРАЛТ 8**

### Сумдын удирдлагын утасны дугаар, хаягийн судалгаа

| № | Сумын нэр | Овог, нэр | Албан тушаал | Гэрийн хаяг | Утасны дугаар |
|---|---|---|---|---|---|
| 1 | Баян-Овоо | Б.Ганбаатар | ИТХ-ын дарга | ......сумын ....р багийн Хэрлэнгийн.... тоот | 9956......... |
| | | ........................... | Засаг дарга | ........................... | ........................... |
| | | ........................... | Орлогч дарга | ........................... | ........................... |
| | | ........................... | Тамгын дарга | ........................... | ........................... |
| 2 | ........................... | ........................... | ИТХ-ын дарга | ........................... | ........................... |

**ХАВСРАЛТ 9**

**Барилга, байгууламжийн судалгаа хэсэг:**

Төр, захиргааны байгууллагуудын барилгын судалгаа
Боловсролын байгууллагуудын барилгын судалгаа
Эрүүл мэндийн байгууллагуудын барилгын судалгаа
Орон сууцны барилгын судалгаа гэх мэт төрөлжүүлж оруулна.

**....................суманд үйл ажиллагаа явуулж буй Төр, захиргааны байгууллагуудын барилгын судалгаа**

| № | Байгууллагын нэр | Ашиглалтад орсон он | Газар хөдлөлтийн тэсвэржилт | Гал тэсвэржилтийн зэрэг | Үндсэн бүтээц | Эзлэхүүн м3 | Талбай М2 | Давхрын тоо | Зоорийн давхартай эсэх | Галын дохиололтой эсэх |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | ЗДТГ | | | | | | | | | |
| 2 | .......... сумын ЗДТГ | | | | | | | | | |

**ХАВСРАЛТ 10**

**................. аймгийн нутаг дэвсгэрт байгаа улсын онц чухал объектод хамаарах байгууллагын судалгаа**

| Байгууллагын нэр | Аль суманд байрлах, ашиглалтад орсон он | Удирдах албан тушаалтны овог нэр, гэрийн хаяг, холбоо барих утас | Байгууллагын товч үзүүлэлт | | | Гамшгийн аюулын дохио дамжуулах арга, нууц код | Дуудлагын бүсэд дэх АГУ анги хүртэлх зай | Дуудлагаар үүрэг гүйцэтгэх шуурхай бүлгийн нэр, удирдагч |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Ажилчдын тоо | Савны багтаамж | Шатахуун шингэн хийн төрөл | | | |
| “Петровис” ХХК | | | | | | | | |
| | | | | | | | | |

**ХАВСРАЛТ 11**

## ТҮР ХОРОГДОХ БАЙРНЫ ПЛАН ЗУРАГ




**<u>Нөөц байр</u>**

1. **ЕБС- 1, 2, 5 спорт заал,  Дуу бүжгийн Боржигин чуулга**
2. **Политехникийн коллеж**
3. **Спорт хороо,**
4. **Төмөр замын клуб**




**Уурхайн судалгаа / Уурхайн байршлыг газрын зургаар харуулна./**

| Төрөл | Нэршил | Таван толгойн уурхай |
|---|---|---|
| Ил уурхай | Эзэмшигч, холбоо барих утас | Энержи ресурс ХХК |
| | Юуны | Нүүрс |
| | Байршил | Цогтцэций сум |
| | Координат | 43,36,161 104,25,833 |
| | Аймгаас аль зүгт хэдэн км-т | Зүүн урд 110 км-т |
| | Сумаас аль зүгт хэдэн км-т | Цогтцэций сумаас баруун урд зүгт 8 км-т |
| Гүний уурхай | Нэршил | |
| | Эзэмшигч, холбоо барих утас | |
| | Юуны | |